**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**
**Жигжидсүрэнгийн ЧИНБҮРЭН**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-46-78, Факс: 32-70-16
E-mail: chinburenj@parliament.mn
http://www.parliament.mn

2025.03.31 № УИХ-03/3757

танай ____________-ны №____________-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ДАШЗЭГВИЙН
АМАРБАЯСГАЛАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу “Цусны донорын тухай” анхдагч хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Ж.ЧИНБҮРЭН

Ж.АЛДАРЖАВХЛАН

А.АРИУНЗАЯА

Н.БАТСҮМБЭРЭЛ

2025000239

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**
**Жигжидсүрэнгийн ЧИНБҮРЭН**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-46-78, Факс: 32-70-16
E-mail: chinburenj@parliament.mn
http://www.parliament.mn

2025.03.31 № ЧИ-03/3733
танай ____________-ны №____________-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БААСАНДОРЖ ТАНАА

Тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу “Цусны донорын тухай” анхдагч хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Монгол улсын Засгийн газраас хуулийн төсөлд санал, дүгнэлт гаргуулахаар 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн УИХ-03/2040 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй тул, Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.12 дахь хэсэгт заасны дагуу тусгайлан өгөх саналгүй гэж үзсэн болно.

Хуулийн төслийг холбогдох хууль, журмын дагуу Монгол Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх товыг тогтоож өгнө үү.

Хуулийн төслийг холбогдох баримтын хамт хавсаргав.
Хавсралт 114 хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ж.ЧИНБҮРЭН

2025000133

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Жигжидсүрэнгийн ЧИНБҮРЭН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-46-78, Факс: 32-70-16
E-mail: chinburenj@parliament.mn
http://www.parliament.mn

2025.02.13 № УИХ-03/2040
танай ______ -ны № ______ -т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

Хуулийн төсөлд санал
авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ дагуу "Цусны донорын тухай" хуулийн төслийг санаачлан боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын санал, дүгнэлтийг авахаар хүргүүлж байна.

"Цусны донорын тухай" хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.11 дэх хэсэгт заасны дагуу саналаа ирүүлнэ үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга болон холбогдох материалыг хавсаргав.

Хавсралт 90 хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ж.ЧИНБҮРЭН

2025000210

БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.ЧИНБҮРЭН

**ЦУСНЫ ДОНОРЫН ТУХАЙ**
**ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

**1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Үндсэн Хуулийн Арван зургадугаар зүйлд “1/Монгол Улсын иргэн амьд явах, 6/эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах...” эрхтэй гэж заасан. Нэгдсэн Үндэсний Байгууллагын ерөнхий ассамблейгаас баталсан Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтын 3-т нийгмийн эрүүл мэндийн бүх нийтээр хамралтад хүрэх зорилтыг тодорхойлж, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүний эрхийг хангахын тулд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг гишүүн орнууддаа зөвлөсөн.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) “Цусны аюулгүй байдлын Санамж бичиг – 8 (2002-2018), Дэлхийн эрүүл мэндийн ассамблейн чуулганы WHA 28.72 (1975), 58.13 (2005), 63.12 (2010) тогтоолыг тус тус баталсан. ДЭМБ-ын Улс үндэстнүүдийн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад зориулсан санамж бичиг, үндэсний хэмжээний эрүүл мэндийн бодлого боловсруулагчдад зориулсан санамж бичиг, цусны талаарх үндэсний хөтөлбөрийг боловсруулахад анхаарах санамж бичигт үндэсний хэмжээний зохицуулгатай, сайтар зохион байгуулагдсан, бүх шатанд үр дүнтэй ажилладаг цусны албыг байгуулах, цус, цусан бүтээгдэхүүний хүрэлцээ, хангамж, аюулгүй байдлыг үнэлэх, цусны албыг хөгжүүлэх зэрэг бодлогын чанартай шийдвэр гаргах үүрэг бүхий үндэсний удирдах байгууллагыг байгуулах, сайн дурын авлагагүй доноруудаас цус цуглуулж байх, цусыг эмчилгээнд зохистой хэрэглэхийг зөвлөмж болгосон.

Дэлхийн бүх улс оронд цус, сэлбэлт судлалын тусламж, үйлчилгээг ямар нэг хэмжээгээр хийж гүйцэтгэж байгаа бөгөөд эдгээрээс 128 улс цусыг эмнэлзүйн практикт зохистой хэрэглэх талаар үндэсний удирдамжтай бөгөөд харин Монгол улс 2000 онд Донорын тухай хууль батлагдсанаар цусны донорын үйл ажиллагааг хуульчилсан 43 дахь улс болсон байна.

Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулах” гэсэн зорилт дэвшүүлсэн. ““Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 2.2.10-д “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.”, 2.2.11-т “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна”, 2.2.15-д “Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний үеийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор олон улсын жишигт нийцсэн төвийг төрөлжүүлэн байгуулна (Зүрх судасны төв, Эрхтэн шилжүүлэн суулгах төв, Яаралтай тусламжийн үндэсний төв гэх мэт)” гэж тус тус заасантай уялдуулан Цус сэлбэлт судлалын салбарын зохион байгуулалт, бүтцийг шинэчлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн тасралтгүй байдлыг хангах шаардлага тулгарч байгаа тул дээрх бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах хүрээнд УИХ-ын 2021 оны “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 12 дугаар тогтоолд Цусны донорын тухай хууль батлахаар тусгасан.

Түүнчлэн Монгол Улсад мөрдөж байгаа Донорын тухай хуульд орсон удаа дараагийн нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгаар эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээг зохицуулах харилцаатай холбоотой зохицуулалт голчлон тусгагдаж ирснээс цус, сэлбэлт судлалтай холбоотой харилцаанд эрх зүйн зөрчил, хийдэл үүсч ирснийг арилгах шаардлага үүссэн. Тухайлбал, сүүлийн 20 жилийн хугацаанд Донорын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдээр манай улсад нутагшуулж байгаа эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний шинэ технологиудтай холбоотой эрх зүйн зохицуулалтуудыг бий болгох зорилтыг шийдэж ирснээс ард иргэдэд сурталчлах, таниулах, алдаршуулж, урамшуулах зайлшгүй шаардлагатай цусны донорын үйл ажиллагааг эрхтний наймаа болон эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний туризмын эсрэг тунхаглал[1] -аар баталсан нийтэд сурталчлах нь эд, эрхтэн шилжүүлэх жуулчлал бий болох, хөгжих үндэс болдог тул уг хэрэгт татан оролцуулахаас хориглох стратегитай зөрчилддөг харилцааг хамтад нь зохицуулах боломжгүй болж, зарим талаар цусны донорын үйл ажиллагааг зохицуулсан харилцаа ойлгомжгүй, эсхүл эд эрхтний наймаа бий болох эрсдлээс сэргийлсэн харилцаанд хамрагдах зэргээр хэт хүндрэлтэй болсон байна. Цус сэлбэлт судлалтай холбоотой цусны донор, цус сэлбүүлэгчийн эрх, үүрэг, тавигдах шаардлага, цусны албаны онцлог, мэргэжлийн нарийн төвөгтэй олон асуудлууд зохицуулагдаагүй

[1] Турк, Истанбул хот, 2008 оны 5 дугаар сард батлагдсан.

орхигдсон буюу Донорын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг боловсруулах явцад энэ бүх асуудлуудыг нэмэлт өөрчлөлтөд багтаан оруулах боломжгүй байснаас болжээ.

Эдгээр бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлага гарсан болно.

**1.2.Практик үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Их Хурлаас Донорын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр баталж одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хэдий ч цусны донорын үйл ажиллагааны зохицуулалтын хуулинд эрхтэн, эд, эсийн эмчилгээний зарим зохицуулалтыг хавсарган оруулж ирснээс өнөөгийн цаг үеийн шаардлагыг бүрэн хангахгүй болсон тул практик, үйл ажиллагааны явцад бий болсон эдгээр асуудлуудыг зохицуулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх бие даасан хууль боловсруулах зайлшгүй хэрэгцээ шаардлага үүссэн.

Монгол улсад анх 1939 оноос цус сэлбэлтийн тусламж үйлчилгээ үзүүлж ирсэн боловч 1963 оноос Сайд нарын зөвлөлийн шийдвэрээр бие даасан нэгж анх байгуулагдаж, цусны донорын хөдөлгөөнийг идэвхижүүлэх, донорыг алдаршуулах, урамшуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байсан. Манай улс хүн ам цөөтэй, эдийн засаг, санхүүгийн хувьд хязгаарлагдмал бололцоотой хэдий ч Улсын Их Хурлаас 2007 онд "Монгол Улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлого" баталсан бөгөөд уг бодлогын хэрэгжилтийг хангах төлөвлөгөө (2008-2015 он)-г Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 111 дүгээр тогтоолоор батлан 5 зорилтын хүрээнд 41 арга хэмжээ төлөвлөн 96,97%-ийн үзүүлэлттэй хэрэгжилтийг хангаж ажилласан. Дээрх арга хэмжээний дунд цус сэлбэлтээр дамжих халдвар болох ХДХВ, Гепатит В, С вирусын халдвар илрүүлэх нуклейн хүчил олшруулах шинжилгээг орчин үеийн аргаар хийх, аюулгүй байдлыг бүрэн хангасан цус, цусан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, өөрийн нөөц боломжийн хэмжээнд хадгалах боломж бүрдсэн.

Өндөр хөгжилтэй орнуудад цус, цусан бүтээгдэхүүний 75 хувийг 65-аас дээш насны хүн амд хэрэглэдэг, бага, дунд орлоготой орнуудад 52 хувийг нь 0-5 насны хүүхдэд хэрэглэгдэг дэлхийн статистик байдаг бол манай улсын хувьд цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэгч өвчтнүүдийн 50.5 хувь нь 36-65 насны хүмүүс буюу идэвхитэй донорын насныхан байна.

Монгол улсад 2021 оны байдлаар нийт цусны донорын 74 хувь нь 40 хүртэл насны иргэд байгаа бөгөөд хүн амын суваргын хэтийн төлөвөөр идэвхтэй донор /24-45 нас/-ын хүн амын тоонд эзлэх хувь дунджаар 2 дахин буурахаар байгаа бөгөөд дунджаар 20 орчим жил үргэлжлэх цонх үеийн цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн тасралтгүй байдлыг хангах нь тулгамдсан гол асуудал болохоор байна.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн орон тоо 2014 оноос хойш 20 гаруй хувь[2] нэмэгдсэн байхад цус, түүний бүрэлдэхүүн хэсэг цуглуулалт, шинжилгээ, үйлдвэрлэлийн хэмжээ 2021 оны байдлаар 85-109.1 хувь болж нэмэгдэн, 2035 он гэхэд дахин 210-275 хувь өсөх тооцоолол гарч байна. Энэ ачааллыг өнөөгийн хүний нөөцийн хэмжээгээр давах ямар ч боломжгүй төдийгүй цус сэлбэлт судлалын салбарын зохион байгуулалтыг боловсронгуй болгох замаар цусны салбар төвүүдийг статус, дэлхий нийтээр баримтлаж байгаа “нэгдсэн тогтолцоо”-нд үе шаттайгаар шилжих асуудлыг тодорхойлох шаардлагатай байна.

Цусны донор, цус сэлбүүлэгчид тавигдах шаардлага, тэдний эрх, үүрэг, тэдэнд эрүүл мэндийн үзлэг хийх, цус, түүний бүрэлдэхүүн хэсэг авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, цус, цусан бүтээгдэхүүнийг эмнэлгийн хэрэгцээнд хэрэглэхтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан бий болгох шаардлагатай байна.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах зорилгоор Засгийн газар, Улсын онцгой комиссоос авсан хариу арга хэмжээний хүрээнд удаа дараа бүрэн болон хэсэгчилсэн хөл хорионы дэглэм тогтоож ирснээс шалтгаалан цус цуглуулалтын хэмжээ буурсан бөгөөд хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний дүнд эмнэлгийн хэрэгцээт цус, цусан бүтээгдэхүүний тасалдалгүйгээр цар тахлын хүнд үеийг даван гарч чадлаа. Гэвч энэ төрлийн эрсдэлд шуурхай хариу арга хэмжээ үзүүлэхэд байнгын бэлэн байдалд байдаг үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын бие бүрэлдэхүүн, төрийн албан хаагчдыг цусны донорын үүрэг гүйцэтгүүлэхтэй холбоотой зохицуулалт үгүйлэгдэж байна.

Ажлын хэсэг цус сэлбэлт судлалын үндэсний төвийн болон орон нутаг дахь цусны салбар төвийн ажилтнуудаас Донорын тухай хууль өнөөгийн шаардлагад нийцэж буй эсэх, цаашид зохицуулах шаардлагатай асуудал зэргээр судалгаа авч дүгнэсэн. Судалгаагаар цус сэлбэлт судлалын үндэсний төв тусгай мэргэжлийн төвийн хувьд улсын төсвөөс санхүүжиж байхад цусны салбар төвүүд орон нутгийн нэгдсэн эмнэлэгт харьяалагдаж “Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай” хуулийн дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжихээр болж байгаагаас цусны салбар төвийн мэргэжилтнүүдэд орон тоо, цалин, хөлстэй холбоотой хүндрэл үүсэх, хүний нөөцийн тогтвортой байдал алдагдах, зарим цусны салбар төвийн өрөө, тасалгааг өөр зорилгоор ашиглахаар шилжүүлсэн гэх асуудал ч гарах болсон нь зөвхөн цус сэлбэлт судлалын салбарт ч биш эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйл болж болзошгүй байна. Иймээс цус сэлбэлт судлалын салбарт ажилладаг эрүүл мэндийн ажилтнуудыг урамшуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх, тэдний нийгмийн асуудлыг дэмжих асуудал тулгамдаж байна.

---

[2] ЦССҮТ-ийн хүний нөөцийн судалгаа 2014-2021 он

Цусны доноруудаас авсан судалгаагаар цусны байнгын донорт дэмжлэг үзүүлэх, тэдний эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, халамжийн асуудлыг сайжруулах, цус өгсөн донорт илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүнээр үйлчлэх, хүн амын дунд ялангуяа оюутан, сурагчдад цусны донорын нийгмийн ач холбогдлыг таниулсан сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх, цусны донорын үйл ажиллагааг дэмжин хамтран ажилласан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулах, цусны донорын үйл ажиллагааг дэмжин зарцуулсан зардлыг нь татвараас чөлөөлөх зэрэг цусны нөөц хангамжийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчин бий болгох, үндэсний аюулгүй байдалтай холбоотой онцлог салбарын хувьд төрөөс цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн талаар онцгойлон анхаарах шаардлагатай байна.

Манай улсын хувьд цусны донорын үйл ажиллагаа сайн дурын, авлагагүй зарчимд үндэслэдэг тул тэдэнд мөнгө биш төр, засгийн шагнал олгох хэлбэрээр алдаршуулж байх, тэдний нийгмийн халамжийг сайжруулах нь байнгын донорын тоог дээшлүүлэхэд түлхэц болно.

Мөн цусны донорын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн аюулгүй байдал, нууцлал, бэлэн байдлын асуудлыг “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” хуульд нийцүүлэн хуульчлах хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

**Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа,хамрах хүрээ**

Хуулийн төслийн зорилго нь цус сэлбэлт судлалын тусламж үйлчилгээний эрх зүйн орчинг бүрдүүлэх, цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийг сайжруулах, тэгш, хүртээмжтэй болгох, авлагагүй, сайн дурын байх зарчмыг баримтлах, цусны донор, сэлбүүлэгч, эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг, тэдэнд тавигдах шаардлагыг тодорхойлох, нэгдсэн бүртгэл мэдээллийн сан байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, цусны донорыг алдаршуулж, урамшуулах болон бусад нийгмийн хамгаалал, дэмжлэгийн арга хэмжээг тодорхой болгох, цусны донорын сургалт, сурталчилгаа, алдаршуулалт, урамшуулалд дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгж байгууллагад татварын хөнгөлөлт үзүүлэх, цус сэлбэлт судлалын тусгай мэргэжлийн төвийн бүрдүүлдэг төсвийн орлогыг, төвийн үйл ажиллагааг дэмжих, чадавхийг сайжруулах, энэ салбарын эмч, ажилчдын цалин хөлс, урамшууллыг дээшлүүлэх замаар нийгмийн асуудлыг шийдвэрлэж, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, цус сэлбэлт судлалыг шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл болгохын хувьд хэрэгцээт тоног төхөөрөмж багаж, хэрэгсэлийн нөхөн хангалтад зарцуулах, цус сэлбэлт судлалын чиглэлийн судалгаа, төгсөлтийн дараах сургалтын санхүүжүүлэлтийг шийдвэрлэхтэй холбоотой харилцаануудыг зохицуулахад оршино.

Хуулийн төсөл дараах бүтэцтэй байна:

1. Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт хуулийн зорилго, хуульд тодорхойлогдох шаардлагатай нэр томьёоны тодорхойлолтыг тусгана. Үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тодорхойлно.

2 Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт үйл ажиллагааг зохион байгуулах удирдлагын тогтолцоог тодорхойлж, Монгол Улсын засгийн газар болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын бүрэн эрхийг тусгана. Мөн цус сэлбэлт судлалын харилцаанд оролцогч төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын албан тушаалтан, эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг, санхүүжилтийн тогтолцоог тусгана.

3. Хуулийн гуравдугаар бүлэгт цусны донор, сэлбүүлэгч, эрүүл мэндийн байгууллага, ажилтанд тавигдах шаардлага, тэдний эрх, үүргийг тодорхойлно.

4. Хуулийн дөрөвдүгээр бүлэгт цусны донорын эгнээг өргөжүүлэхтэй холбоотой сургалт, сурталчилгаа, алдаршуулалт, урамшуулалт, нийгмийн халамж, дэмжлэгийг тусгана.

5. Хуулийн тавдугаар бүлэгт цусны донороос цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг эмчилгээний зориулалтаар авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, сэлбэх үйл ажиллагааны зохицуулалтыг тусгана.

6. Хуулийн зургадугаар бүлэгт гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн цусны донорын үйл ажиллагааг тусгана.

7. Хуулийн долдугаар бүлэгт цусны донорын мэдээллийн сантай холбоотой зохицуулалтыг тусгана.

8. Хуулийн наймдугаар бүлэгт хариуцлагын хэсгийг тусгана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм,хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар**

1. Цусны донорын үйл ажиллагаан дахь төрийн зохицуулалт, хяналт сайжирч өнөө хир бүрэн зохицуулагдаагүй байгаа цус сэлбэлт судлалын тусламж, үйлчилгээний удирдлагын тогтолцоотой холбоотой харилцаа бүрэн зохицуулагдах боломж бүрдэнэ.
2. Цусны донорын харилцаанд оролцогч байгууллагууд, үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо, харилцаанд оролцогч талууд, түүний дотор цусны донорны үйл ажиллагаа хариуцсан байгууллага, цусны салбар төв, нутгийн өөрөө удирдах байгууллага, засаг дарга, бусад байгууллагын эрх, үүргийг тодорхойлж, цус сэлбэлт судлалын салбарын эмнэлгийн мэргэжилтнүүдийн нийгмийн хамгаалал сайжирна.
3. Санхүүжилтийн тогтолцоо боловсронгуй болсноор цусны донорт үзүүлэх дэмжлэг, цус сэлбэлт судлалын салбарт ажиллагсдын цалин, нийгмийн асуудал сайжрах, аж ахуйн нэгжүүдийн цусны донорын үйл ажиллагааг дэмжин оролцох сонирхол нэмэгдэж, цусны донорын тоо нэмэгдэх нөхцөл бүрдэнэ.

4. Цусны донор, сэлбүүлэгч, цус сэлбэлт судлалын салбарын эмнэлгийн мэргэжилтэнд тавигдах шаардлага, тэдгээрийн эрх, үүрэг тодорхой болсноор дээрх харилцаанд оролцогч иргэд, эмнэлгийн мэргэжилтний эрх, хууль ёсны ашиг сонирхол хангагдана.

5. Цусны донорын алдаршуулалт, урамшуулалт, тэдгээрт үзүүлэх дэмжлэг сайжирна.

6. Донороос цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, сэлбэх, устгах үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын оролцоог тодорхойлж, хуулийн төсөл батлагдсанаар цус сэлбэлт судлалын тусламж үйлчилгээний хүрээ нэмэгдэх, тусгай мэргэжлийн төвд мөрдөж буй стандартын дагуу шинжилж, үйлдвэрлэсэн цус, цусан бүтээгдэхүүнээр орон нутагт эмчилгээ үйлчилгээг авах боломж бүрдэж, иргэдийн амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх хангагдана.

7. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед цусны донорын үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт бий болох бөгөөд хуулийн төсөл батлагдсантай холбоотой гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед цус, цусан бүтээгдэхүүний хангамжийн тасралтгүй байдал сайжирч, нөөц бүрдүүлэхтэй холбоотой төсөв, санхүүгийн нэмэлт зардал гарах болно.

8. Цусны донорын мэдээллийн сан бий болгох, ажиллуулах, бүрдүүлэх байгууллагын эрх зүйн үндэс бүрдэж, цусны донорыг танин тодруулах, тэднийг алдаршуулах, урамшуулах, дэмжлэг үзүүлэх боломж сайжирна.

**Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, бусад хуультай нийцсэн байх бөгөөд уг хуулийн төсөлтэй холбогдуулан Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

---oOo---

# ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"Цусны донорын тухай" хуулийн төслийн тухай

Монгол улсад анх 2000 онд Донорын тухай хууль батлагдаж байсан бөгөөд энэ хуулийн үндсэн санаа, агуулга нь цусны донорын үйл ажиллагааг зохицуулах зориулготой байсан бөгөөд 2012, 2014, 2015, 2021 онуудад нэмэлт, өөрчлөлт хийсэн байна. Энэ хугацаанд манай улсын анагаах ухааны салбарт эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээ хөгжин, эмчилгээний арга хэлбэр, тоо, чанар зэрэг нь хөгжлийн шинэ үе шатанд гарсантай уялдан дээр дурьдсан удаа дараагийн нэмэлт, өөрчлөлт болон шинэчилсэн найруулгаар эрхтний донор, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний талаарх заалтууд нэмж тусгагдсаар ирсэн.

**Монгол Улсад цус сэлбэлт судлалын салбар хөгжиж ирсэн талаар:**

Монгол улсад анх 1939 оноос цус сэлбэлтийн тусламж үйлчилгээ үзүүлж ирсэн боловч 1963 оноос Сайд нарын зөвлөлийн шийдвэрээр бие даасан нэгж анх байгуулагдаж, цусны донорын хөдөлгөөнийг идэвхижүүлэх, донорын алдаршуулах, урамшуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байсан. Улсын Их хурлаас 2007 онд "Монгол Улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлого" баталсан бөгөөд уг бодлогын хэрэгжилтийг хангах төлөвлөгөө (2008-2015 он)-г Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 111 дүгээр тогтоолоор батлан 96,97% -ийн үзүүлэлттэй хэрэгжилтийг хангаж ажилласан.

**Ирээдүйн чиг хандлага, түүний төсөөллийн талаар:**

Монгол улсын хүн амын суваргын хэтийн төлвөөр идэвхитэй донор /24-45 нас/-ын хүн амын тоонд эзлэх хувь дунджаар 2 дахин буурахаар байгаа бөгөөд дунджаар 20 орчим жил үргэлжлэх цонх үеийн цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн тасралтгүй байдлыг хангах нь бидний өмнө тулгамдсан гол асуудал болж байна.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн орон тоо 2014 оноос хойш 20 гаруй хувь нэмэгдсэн байхад цус, түүний бүрэлдэхүүн хэсэг цуглуулалт, шинжилгээ, үйлдвэрлэлийн хэмжээ улам бүр нэмэгдэн, энэ ачааллыг өнөөгийн хүний нөөцийн хэмжээгээр давах ямар ч боломжгүй болсон төдийгүй Цус сэлбэлт судлалын салбарыг дэлхий нийтээр баримтлаж байгаа "Нэгдсэн тогтолцоо"-нд үе шаттайгаар шилжих асуудлыг тодорхойлох шаардлагатай байна.

Ажлын хэсэг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн болон орон нутаг дахь Цусны салбар төвийн ажилтнууд, Цусны донoруудаас авсан судалгаагаар орон тоо, цалин, хөлстэй холбоотой хүндрэл үүсэх, хүний нөөцийн тогтвортой байдал алдагдах, нэгэнт бий болсон чадамж буурах үзэгдэл гарч эхэлсэн, цусны байнгын донорт дэмжлэг үзүүлэх, тэдний эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, халамжийн асуудлыг сайжруулах, цус өгсөн донорыг илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүнээр үйлчлэх, хүн амын дунд цусны донорын нийгмийн ач холбогдлыг таниулсан сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх, урамшуулах, цусны донорын үйл ажиллагааг дэмжин зарцуулсан зардлыг нь татвараас чөлөөлөх зэрэг цусны нөөц хангамжийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчин бий болгох, үндэсний аюулгүй байдалтай

холбоотой онцлог салбарын хувьд төрөөс цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн талаар онцгойлон анхаарах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан.

**Баримтлах бодлогын чиг баримжаа :**

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын удаа дараагийн тогтоол, зөвлөмж, санамж бичиг, Улсын их хурлаас баталсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", ""Алсын хараа 2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа", "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай" тогтоолыг тус тус Цусны донорын тухай төслийг боловсруулах чиг баримжаа болгов.

**Дэлхийн улс орон олон улсын жишиг:**

ДЭМБ-ын 2018 оны мэдээгээр Цусны алба бүхий 171 улсаас 123 улс нь Үндэсний бодлоготой, 110 улс нь Цус сэлбэлтийн аюулгүй байдал, чанарыг зохицуулах тусгай хуультай байгаа бөгөөд өргөн барьж буй Цусны донорын тухай хуулийн төслийг боловсруулахдаа холбогдох судалгаа болон Гүрж, ОХУ, БНХАУ -ын ижил төстэй байгууллагуудын хууль тогтоомж, журам, зааврууд, ДЭМБ-ын удаа дараагийн цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, хангамжтай холбоотой Санамж бичиг, зөвлөмжийг өөрийн орны нөхцөл байдал мөрдөгдөж буй хууль, тогтоомжтой уялдуулан нийт 8 бүлэг, 35 зүйлтэйгээр боловсрууллаа.

**Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн хэрэгжилт, үр нөлөө сайжирч, дараах эерэг үр дүн гарна гэж тооцоолж байна:**

1. Цус сэлбэлт судлалын салбарын эрх зүйн орчин улам боловсронгуй болж, цус сэлбэлт судлалын салбар хөгжин дэвших шинэ боломжууд нээгдэнэ.
2. Иргэд эх орондоо дэлхийн жишигт нийцсэн чанартай тусламж, үйлчилгээг хүртээмжтэй хүртэх боломж нэмэгдэнэ.
3. Цусны донорын сургалт, сурталчилгаа, түүний дотор орон нутаг дахь үйл ажиллагаанд ахиц дэвшил гарна.
4. Цусны донор, сэлбүүлэгч, эмнэлгийн мэргэжилтэнд тавигдах шаардлага, тэдний эрх, үүрэг тодорхой болно
5. Цусны донорын нийгмийн халамж, алдаршуулалт, урамшуулал сайжирч, цусны донорын тоо нэмэгдэнэ.
6. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамж бүрэн шийдэгдэх нөхцөл бүрдэнэ.

**Хууль санаачлагч**

# ТАНИЛЦУУЛГА

“Цусны донорын тухай” хуулийн төслийн тухай

Монгол улсад анх 2000 онд Донорын тухай хууль батлагдсан бөгөөд тус хуулийн үндсэн санаа, агуулга нь цусны донорын үйл ажиллагааг зохицуулах зорилготой байсан хэдий ч эрхтний донор, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний талаарх заалтыг хамтад нь зохицуулж байна. Энэ хугацаанд манай улсын анагаах ухааны салбарт эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээ улам хөгжин, өргөжин тэлж, эмчилгээний арга хэлбэр, тоо, чанар зэрэг нь хөгжлийн шинэ үе шатанд гарсаар байгаа билээ. Монгол Улсын Их Хурлаас Донорын тухай хуулинд 2012, 2014, 2015, 2021 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна. Шинэчилсэн найруулгаар нийт 4 бүлэг, 40 орчим зүйл, хэсэг, заалтад нэмэлт өөрчлөлт оруулж, 15 нэр томъёог шинээр оруулсан байна. Тус хуулиар хүний эрүүл мэндийг хамгаалах, амь насыг нь аврах зорилгоор сайн дураараа цус, эс, эд, эрхтнээ үнэ төлбөргүй өгөх, шилжүүлэн суулгах, цусны аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагаа болон уг үйл ажиллагааны талаархи төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэний эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Хүний эрүүл мэнд, амь насыг аврах цаг үеийн хэрэгцээ шаардлагыг шуурхай хангах зорилгоор эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан хэдий ч тус хууль нь эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний тухай салбар эрх зүйн акт бий болгох, цаашлаад цусны донорын асуудлаарх хамрах хүрээ, үзэл баримтлал, процессын зохицуулалтуудыг бүхэлд нь шийдэх боломжгүй болж буй тул энэхүү хуулийг боловсруулах үндсэн шаардлага бий болж байна.

**Монгол Улсад цус сэлбэлт судлалын салбар хөгжиж ирсэн талаар:**

Монгол улсад анх 1939 оноос цус сэлбэлтийн тусламж үйлчилгээ үзүүлж ирсэн боловч 1963 оноос Сайд нарын зөвлөлийн шийдвэрээр бие даасан нэгж анх байгуулагдаж, цусны донорын хөдөлгөөнийг идэвхижүүлэх, донорыг алдаршуулах, урамшуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байсан. Манай улс хүн ам цөөтэй, эдийн засаг, санхүүгийн хувьд хязгаарлагдмал бололцоотой хэдий ч Улсын Их Хурлаас 2007 онд “Монгол Улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлого” баталсан бөгөөд уг бодлогын хэрэгжилтийг хангах төлөвлөгөө (2008-2015 он)-г Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 111 дүгээр тогтоолоор батлан 5 зорилтын хүрээнд 41 арга хэмжээ төлөвлөн 96,97% -ийн үзүүлэлттэй хэрэгжилтийг ханган ажилласан. Дээрх арга хэмжээний дунд цус сэлбэлтээр дамжих халдвар болох ХДХВ, Гепатит В, С вирусын халдвар илрүүлэх нуклейн хүчил олшруулах шинжилгээг орчин үеийн аргаар хийх, аюулгүй байдлыг бүрэн хангасан цус, цусан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, өөрийн нөөц боломжийн хэмжээнд хадгалах боломж бүрдсэн.

Манай улсын хэмжээнд 2021 оны байдлаар 19337 цусны донор бүртгэгдсэнээс 7837 донор тогтмол цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ бэлэглэж, цуглуулсан цусны нэгж бүрт цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээ хийж, 36 нэр

төрлийн 103265 нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 61675 нэгж цус, цусан бүтээгдэхүүнийг эмнэлэгт олгоод байна. Бүтээгдэхүүний 78%-ийг цус сэлбэлт судлалын үндэсний төв дангаар бүрдүүлсэн бөгөөд 22%-ийг нь бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, зарим сум дахь нэгдсэн эмнэлгийн дэргэдэх цусны салбар төвд бэлтгэн эмчилгээнд олгосон байна.

Өндөр хөгжилтэй орнуудад цус, цусан бүтээгдэхүүний 75 хувийг 65-аас дээш насны хүн амд хэрэглэдэг, бага, дунд орлоготой орнуудад 52 хувийг нь 0-5 насны хүүхдэд хэрэглэгдэг дэлхийн статистик байдаг бол манай улсын хувьд цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэгч өвчтнүүдийн 50.5 хувь нь 36-65 насны хүмүүс буюу идэвхитэй донорын насныхан байна.

**Ирээдүйн чиг хандлага, түүний төсөөллийн талаар:**

Монгол улсын хүн амын суваргын хэтийн төлөвөөр идэвхитэй донор /24-45 нас/-ын хүн амын тоонд эзлэх хувь дунджаар 2 дахин буурахаар байгаа бөгөөд дунджаар 20 орчим жил үргэлжлэх цонх үеийн цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн тасралтгүй байдлыг хангах нь тулгамдсан гол асуудал болж байна.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах зорилгоор Засгийн газар, Улсын онцгой комиссоос авсан хариу арга хэмжээний хүрээнд удаа дараа бүрэн болон хэсэгчилсэн хөл хорионы дэглэм тогтоож ирснээс шалтгаалан цус цуглуулалтын хэмжээ буурсан бөгөөд хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний дүнд эмнэлгийн хэрэгцээт цус, цусан бүтээгдэхүүний тасалдалгүйгээр цар тахлын хүнд үеийг даван гарсан. Гэвч энэ төрлийн эрсдэлд шуурхай хариу арга хэмжээ үзүүлэхэд байнгын бэлэн байдалд байдаг үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын бие бүрэлдэхүүн, төрийн албан хаагчдыг цусны донорын үүрэг гүйцэтгүүлэх, анагаахын боловсрол олгодог боловсролын байгууллагын хөтөлбөрт цус сэлбэлт судлалын хөтөлбөр тусгахтай холбоотой зохицуулалт шаардлагатай нь харагдаж байна.

Цусны донор, цус сэлбүүлэгч, эмнэлгийн мэргэжилтэнд тавигдах шаардлага, тэдний эрх, үүрэг, тэдэнд эрүүл мэндийн үзлэг хийх, цус, түүний бүрэлдэхүүн хэсэг авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, цус, цусан бүтээгдэхүүнийг эмнэлгийн хэрэгцээнд хэрэглэхтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан бий болгох шаардлагатай байна.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн орон тоо 2014 оноос хойш 20 гаруй хувь нэмэгдсэн байхад цус, түүний бүрэлдэхүүн хэсэг цуглуулалт, шинжилгээ, үйлдвэрлэлийн хэмжээ 2021 оны байдлаар 85-109.1 хувь болж нэмэгдэн, 2035 он гэхэд дахин 210-275 хувь өсөх тооцоолол гарч байна. Энэ ачааллыг өнөөгийн хүний нөөцийн хэмжээгээр давах ямар ч боломжгүй байгаа төдийгүй цус сэлбэлт судлалын салбарын зохион байгуулалтыг боловсронгуй болгох замаар цусны салбар төвүүдийг статус, дэлхий нийтээр баримталж буй “нэгдсэн тогтолцоо”-нд үе шаттайгаар шилжих асуудлыг тодорхойлох шаардлагатай байна.

Ажлын хэсэг цус сэлбэлт судлалын үндэсний төвийн болон орон нутаг дахь цусны салбар төвийн ажилтнуудаас Донорын хууль өнөөгийн шаардлагад нийцэж

байгаа эсэх, цаашид зохицуулах шаардлагатай асуудал зэргээр судалгаа авч дүгнэсэн. Судалгаагаар цус сэлбэлт судлалын үндэсний төв тусгай мэргэжлийн төвийн хувьд улсын төсвөөс санхүүжиж байхад цусны салбар төвүүд орон нутгийн нэгдсэн эмнэлэгт харьяалагдаж "Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай" хуулийн дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжихээр болж байгаагаас цусны салбар төвийн мэргэжилтнүүдэд орон тоо, цалин, хөлстэй холбоотой хүндрэл үүсэх, хүний нөөцийн тогтвортой байдал алдагдах, зарим цусны салбар төвийн өрөө, тасалгааг өөр зорилгоор ашиглахаар шилжүүлсэн гэх асуудал болсон нь зөвхөн цус сэлбэлт судлалын салбарт ч биш эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйл болж болзошгүй байна. Иймээс цус сэлбэлт судлалын салбарт ажилладаг эрүүл мэндийн ажилтнуудыг урамшуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх, тэдний нийгмийн асуудлыг дэмжих асуудал тулгамдаж байна.

Цусны доноруудаас авсан судалгаагаар цусны байнгын донорт дэмжлэг үзүүлэх, тэдний эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, халамжийн асуудлыг сайжруулах, цус өгсөн донорт илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүнээр үйлчлэх, хүн амын дунд ялангуяа оюутан, сурагчдад цусны донорын нийгмийн ач холбогдлыг таниулсан сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх, цусны донорын үйл ажиллагааг дэмжин хамтран ажилласан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулах, цусны донорын үйл ажиллагааг дэмжин зарцуулсан зардлыг нь татвараас чөлөөлөх зэрэг цусны нөөц хангамжийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчин бий болгох, үндэсний аюулгүй байдалтай холбоотой онцлог салбарын хувьд төрөөс цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн талаар онцгойлон анхаарах шаардлагатай байна.

Манай улсын хувьд цусны донорын үйл ажиллагаа сайн дурын, авлагагүй зарчимд үндэслэдэг тул тэдэнд мөнгө биш төр, засгийн шагнал олгох хэлбэрээр алдаршуулж байх, нийгмийн халамжийг сайжруулах нь нэгэнт Хүндэт донор болсон бол идэвхигүй байдалд шилжиж байгаа байнгын донорын тоог дээшлүүлэхэд түлхэц болох юм.

Цусны донорын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн аюулгүй байдал, нууцлал, бэлэн байдлын асуудлыг ч хуульчлах хэрэгцээ, шаардлага тулгарч байна. Энэхүү нарийн төвөгтэй үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх нь чухал юм.

**Баримтлах бодлогын чиг баримжаа :**

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын удаа дараагийн тогтоол, зөвлөмж, санамж бичиг, Улсын Их Хурлаас баталсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-д "Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулах" гэсэн зорилт дэвшүүлсэн. ""Алсын хараа 2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны 2.2.10-д "Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.", 2.2.11-т "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг

хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна.", 2.2.15-д "Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний үеийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор олон улсын жишигт нийцсэн төвийг төрөлжүүлэн байгуулна (Зүрх судасны төв, Эрхтэн шилжүүлэн суулгах төв, Яаралтай тусламжийн үндэсний төв гэх мэт)" гэж тус тус заасан.

**Дэлхийн улс орон олон улсын жишиг:**

ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу цус цуглуулах, шинжлэх, үйлдвэрлэх, хадгалах, түгээхтэй холбоотой бүхий л үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахын тулд цусны төвүүдийг нэгдсэн /төвлөрсөн, бүсчилэх/ байдлаар үндэсний хэмжээнд зохицуулах ёстой. Цусны чанар, аюулгүй байдлыг хангах, стандартыг жигд мөрдүүлэх, баримтлахын тулд цусны хангамжийн үндэсний тогтолцоог үндэсний бодлого, хууль эрх зүйн хүрээнд дэмжих ёстой. ДЭМБ-ын 2018 оны мэдээгээр цусны алба бүхий 171 улсаас 123 улс нь үндэсний бодлоготой, 110 улс нь цус сэлбэлтийн аюулгүй байдал, чанарыг зохицуулах тусгай хуультай байна.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) "Цусны аюулгүй байдлын Санамж бичиг – 8 (2002-2018), Дэлхийн эрүүл мэндийн ассамблейн чуулганы WHA 28.72 (1975), 58.13 (2005), 63.12 (2010) тогтоолыг тус тус баталсан. ДЭМБ-ын Улс үндэстнүүдийн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад зориулсан санамж бичиг, үндэсний хэмжээний эрүүл мэндийн бодлого боловсруулагчдад зориулсан санамж бичиг, цусны талаарх үндэсний хөтөлбөрийг боловсруулахад анхаарах санамж бичигт үндэсний хэмжээний зохицуулгатай, сайтар зохион байгуулагдсан, бүх шатанд үр дүнтэй ажилладаг цусны албыг байгуулах, цус, цусан бүтээгдэхүүний хүрэлцээ, хангамж, аюулгүй байдлыг үнэлэх, цусны албыг хөгжүүлэх зэрэг бодлогын чанартай шийдвэр гаргах үүрэг бүхий үндэсний удирдах байгууллагыг байгуулах, сайн дурын авлагагүй доноруудаас цус цуглуулж байх, цусыг эмчилгээнд зохистой хэрэглэхийг зөвлөмж болгосон. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Донорын тухай хууль болон өргөн барьж буй Цусны донорын тухай хуулийн төсөл нь эдгээр зарчмуудын хүрээнд боловсрогдон гарч байгаа болно.

Энэхүү хуулийн төсөл нь хуулийн зорилго, хуульд тодорхойлогдох шаардлагатай нэр томьёоны тодорхойлолт, зарчим, үйл ажиллагааг зохион байгуулах удирдлагын тогтолцоо, Монгол Улсын Засгийн газар болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн байгууллагын бүрэн эрх, цус сэлбэлт судлалын харилцаанд оролцогч төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын албан тушаалтан, эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг, санхүүжилтийн тогтолцоо, цусны донор, сэлбүүлэгч, эрүүл мэндийн байгууллага, ажилтанд тавигдах шаардлага, цусны донороос цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг эмчилгээний зориулалтаар авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, сэлбэх, устгах үйл ажиллагааны зохицуулалт, цусны донорын мэдээллийн сан, цусны донорын эгнээг өргөжүүлэхтэй холбоотой сургалт, сурталчилгаа, алдаршуулалт, урамшуулалт, нийгмийн халамж, хариуцлагын хэсгийг тусгасан нийт 8 бүлэг, 35 зүйлтэй байна.

Хуулийн төслийг боловсруулахдаа Эрүүл мэндийн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүд нь Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгааны хүрээлэнгээр хийлгэсэн судалгаа болон Гүрж, ОХУ, БНХАУ -ын ижил төстэй хууль тогтоомж, журам , зааврuудыг судлаж өөрийн орны нөхцөл байдал одоо хэрэгжиж буй хууль журмуудтай уялдуулан зохицуулан боловсруулсан.

Хуулийн төсөл батлагдсанаар хууль хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг улсын төсвөөс нэмж санхүүжүүлэх шаардлагатай.

**Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн хэрэгжилт, үр нөлөө сайжирч, дараах эерэг үр дүн гарна гэж тооцоолж байна:**

1. Цус сэлбэлт судлалын салбарын эрх зүйн орчин улам боловсронгуй болж үүний хэрээр цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамж улам сайжирч, цус сэлбэлт судлалын салбар хөгжин дэвших шинэ боломжууд нээгдэнэ.
2. Иргэд эх орондоо дэлхийн жишигт нийцсэн чанартай тусламж, үйлчилгээг хүртээмжтэй хүртэх боломж нэмэгдэнэ.
3. Цус сэлбэлт судлалын үйл ажиллагааг зохицуулах удирдлагын тогтолцоо, үйл ажиллагаа шинэ шатанд гарна.
4. Цусны донорын сургалт, сурталчилгаа, түүний дотор орон нутаг дахь үйл ажиллагаанд ахиц дэвшил гарснаар эрүүл аж төрөх ёсны талаарх ойлголт сурагч, оюутнаар дамжин өргөжинө.
5. Цусны донор, сэлбүүлэгч, эмнэлгийн мэргэжилтэнд тавигдах шаардлага, тэдний эрх, үүрэг тодорхой болохын дээр тэдний нийгмийн халамж, алдаршуулалт, урамшуулал сайжирч, цусны донорын тоо нэмэгдэнэ.
6. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамж бүрэн шийдэгдэх нөхцөл бүрдэнэ.

**Хууль санаачлагч**

/Төсөл/

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дүгээр сарын .....-ний өдөр

Улаанбаатар хот

## ЦУСНЫ ДОНОРЫН ТУХАЙ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь цусны донорын үйл ажиллагаатай холбоотой төрийн бодлого, зохицуулалт, баримтлах зарчим, тэдгээрийг хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн үндэс, удирдлага, санхүүжилтийн тогтолцоо, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэний нийтлэг эрх, үүрэг, цус сэлбэлт судлалын салбарт ажиллагсдын цалин, хөлс, нийгмийн баталгаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Цусны донорын тухай хууль тогтоомж**

2.1.Цусны донорын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Эрүүл мэндийн тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёо**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“цусны донорын үйл ажиллагаа” гэж цусны донорын сургалт, сурталчилгаа, элсүүлэлт, цусны донор сонгох, цус цуглуулах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, сэлбэх болон цусны аюулгүй байдлыг хангахтай холбоотой цогц үйл ажиллагааг;

3.1.2.“цусны донорын үйл ажиллагааны тогтолцоо” гэж цусны донорын үйл ажиллагаанд тавих төрийн хяналт, оролцоо, байгууллагуудын эрх, үүрэг, санхүүжилтийн тогтолцоог;

3.1.3.“цусны донор" гэж бусдын амь насыг аврах, эрүүл мэндийг сайжруулах зорилгоор сайн дураараа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн хүнийг;

3.1.4.“цус, цусны бүрэлдэхүүн хэсэг" гэж цус, цусны сийвэн, улаан эс, ялтаст эсийг;

3.1.5.“цусны ховор бүлэг” гэж хүн амын дунд цөөн тохиолддог цусны бүлгийг;

3.1.6.“цус, цусан бүтээгдэхүүн" гэж цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг боловсруулж бэлтгэсэн бүтээгдэхүүнийг;

3.1.7.“сэлбүүлэгч" гэж амь нас, эрүүл мэндээ хамгаалуулах зорилгоор цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэх зайлшгүй шаардлагатай хүнийг;

3.1.8.“цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг боловсруулах" гэж батлагдсан стандарт, зааврын дагуу бэлтгэхийг;

3.1.9.“цусны аюулгүй байдал" гэж цусны донорт элсүүлэх, цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, сэлбэх, улсын хилээр нэвтрүүлэх ажиллагаанд хууль, журам, стандартын шаардлага бүрэн хангагдсан байдлыг;

3.1.10.“хөдөлгөөнт иж бүрдэл” гэж цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах, шинжлэх, боловсруулах зориулалтаар тоноглосон тээврийн хэрэгслийг;

3.1.11.“цусны биобэлдмэл" гэж цусны сийвэнгээс гаргаж авсан эмчилгээний бэлдмэлийг;

**4 дүгээр зүйл.Цусны донорын үйл ажиллагаанд баримтлах зарчим**

4.1.Цусны донорын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

4.1.1.хууль, хүний эрхийг дээдлэх;

4.1.2.сайн дурын, авлагагүй байх;

4.1.3.аюулгүй, чанарын баталгаатай байх;

4.1.4.цусны донор, сэлбүүлэгчийн эрүүл мэндийг хамгаалах;

4.1.5.хүний эмзэг мэдээллийг хамгаалах;

4.1.6.цусны донорыг алдаршуулж, урамшуулах.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## ЦУСНЫ ДОНОРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОГТОЛЦОО

**5 дугаар зүйл.Цусны донорын үйл ажиллагаан дахь төрийн зохицуулалт, хяналт**

5.1.Цусны донорын үйл ажиллагааны төрийн зохицуулалт нь сайн дурын, авлагагүй цусны донорын хөдөлгөөнийг идэвхижүүлэх, цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамж, аюулгүй байдлыг хангах, цусны донорын үйл ажиллагааг зохицуулахад чиглэнэ.

5.2.Цус, сэлбэлт судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах, цусны биобэлдмэлийн үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

5.3.Цусны донорын үйл ажиллагаа, чанар, аюулгүй байдал болон цусны донорын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сантай холбоотой хяналтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ. [1]

**6 дугаар зүйл.Цусны донорын үйл ажиллагааны талаархи Засгийн газрын бүрэн эрх**

6.1.Цусны донорын үйл ажиллагааны талаар Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамж, чанар, аюулгүй байдлын талаар баримтлах төрийн бодлогыг Улсын Их Хурлаар батлуулах, биелэлтийг хангах;

6.1.2.Засгийн газар хоорондын болон олон улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

6.1.3.цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамж, чанар, аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх, санхүүжилтийг шийдвэрлэх;

6.1.4.гамшгийн үед цус, цусан бүтээгдэхүүн, тэдгээрийг орлох бэлдмэлийн нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангах;

6.1.5.Засгийн газрын шагнал Цусны хүндэт донор хүндэт тэмдгээр шагнах, тэдэнд дэмжлэг үзүүлэх журам батлах;

6.1.6.цус сэлбэлт судлалын салбарт ажиллагсдын нэмэгдэл цалингийн хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох, нийгмийн баталгааг хангах арга хэмжээ хэрэгжүүлэх;

6.1.7.Нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргын ажлын үзүүлэлтийг гаргах шалгуур үзүүлэлтэд энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан үүргээ хэрэгжүүлсэн байдлыг тусган дүгнэх;

6.1.8.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

**7 дугаар зүйл.Цусны донорын үйл ажиллагаанд оролцогч байгууллага**

7.1.Цусны донороос цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, сэлбэхтэй холбоотой асуудлаар дараах байгууллага хамтран ажиллана:

7.1.1.эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

---

7.1.2.цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төв, цусны төв;

7.1.3.цусны донорын үйл ажиллагаанд оролцогч эрүүл мэндийн байгууллага, анагаах ухааны боловсрол олгодог боловсролын байгууллага;

7.1.4.төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага;

7.1.5.Монголын улаан загалмайн нийгэмлэг, бусад төрийн бус байгууллага;

7.1.6.аж ахуйн нэгж, байгууллага.

**8 дугаар зүйл.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг**

8.1.Цусны донорын үйл ажиллагааны талаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах эрх, үүрэгтэй:

8.1.1.цусны донорын үйл ажиллагааг зохицуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

8.1.2.цусны донорын үйл ажиллагаанд төрийн хяналт хэрэгжүүлэх;

8.1.3.цусны чанар, аюулгүй байдлыг хангах, цусны донорын үйл ажиллагаатай холбоотой журам, зааврыг батлах;

8.1.4.цусны биобэлдмэлийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зохицуулах журам, техник, технологийн чиглэлээр баримтлах чиглэлийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

8.1.5.цусны донорт олгох илчлэг нөхөх хоол, хүнсний бүтээгдэхүүний орц, илчлэгийн жишиг хэмжээг батлах;

8.1.6.цус сэлбэлт судлалын салбарт ажиллагсдын нэмэгдэл цалингийн хэмжээ, нийгмийн баталгааг хангах санал боловсруулах;

8.1.7. цус сэлбэлт судлалын чиглэлээр улсад төгсөлтийн дараах гадаад сургалт, дадлагад хамруулах;

8.1.8.хуульд заасан бусад эрх, үүрэг.

**9 дүгээр зүйл. Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага, түүний эрх, үүрэг**

9.1.Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.12-д заасан тусгай мэргэжлийн төв байна.

9.2.Цус, сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төвийн харьяанд Цусны төв ажиллана.[2] Цусны төвийн бүтэц, дүрмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.3.Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16.15-д заасан эрх, үүргээс гадна дараах эрх, үүрэгтэй:

9.3.1.Цусны донорын үйл ажиллагаа, цусны чанар, аюулгүй байдал, цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээ, цусны сонор сэрэмжийн тогтолцоог үндэсний хэмжээнд удирдлага зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангах;

9.3.2.цусны донорын сургалт, сурталчилгааны ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулах, цусны донор элсүүлэх;

9.3.3.цус, цусны бүрэлдэхүүн хэсэг цуглуулах, шинжлэх, цусны бүлэг тодорхойлох, бүтээгдэхүүний чанарын хяналтын болон бусад шинжилгээ хийх;

9.3.4.цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг боловсруулах;

9.3.5.цусны биобэлдмэл үйлдвэрлэх;

9.3.6.цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн тогтвортой байдлыг хангах;

9.3.7.цусаа өгсөн талаарх магадлагаа олгох;

9.3.8.цусны донорыг алдаршуулах, урамшуулах үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулах;

9.3.9.олон удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн цусны донорыг шагнах, Засгийн газрын болон төрийн шагналд нэр дэвшүүлэх;

9.3.10.цусны донорын мэдээллийн сангийн бүрдүүлэлт, өөрчлөлт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хариуцах талаар хууль, тогтоомжоор тогтоосон үүргийг хэрэгжүүлэх;

9.3.11.цусны донорын үйл ажиллагааны мэдээ, тайланг улсын хэмжээнд нэгтгэх, холбогдох байгууллагад хүргүүлэх;

9.3.12.цусны донороос авсан цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг гагцхүү энэ хуульд заасан хэрэгцээ, шаардлагын дагуу ашиглахад хяналт тавьж, донорын эмзэг мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.[3]

9.4.Цусны төв нь хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд цус, цусан бүтээгдэхүүний нөөц хангамжийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр энэ хуулийн 9.3.2, 9.3.3, 9.3.4, 9.3.6, 9.3.7, 9.3.8, 9.3.10, 9.3.12 -т заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

**10 дугаар зүйл.Цусны донорын үйл ажиллагаанд оролцогч бусад эрүүл мэндийн байгууллага, тэдгээрийн эрх, үүрэг**

10.1. Цусны донорын үйл ажиллагаанд оролцогч эрүүл мэндийн байгууллага нь Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.2, 15.1.3, 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.1.10, 15.1.11, 15.1.12, 15.1.13-т заасан болон энэ хуульд заасан үйл ажиллагаанд оролцогч тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэл бүхий эрүүл мэндийн байгууллага байна.

10.2. Энэ зүйлийн 10.1-д заасан эрүүл мэндийн байгууллага нь дараах эрх, үүрэгтэй:

10.1.1.цус, цусан бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хадгалах, цус сэлбэлтийн өмнөх шинжилгээ хийх, сэлбэх, цусны чанар, аюулгүй байдлыг хангах;

10.1.2.цус, цусан бүтээгдэхүүнийг зохистой хэрэглэх;

10.1.3.цус, цусны бүрэлдэхүүн хэсэг өгсөнтэй холбоотой донорт илрэх сөрөг хариу урвалын үед яаралтай болон нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх;

10.1.4.цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээ болон холбогдох бусад мэдээ, тайланг цус, сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төвд хүргүүлэх.

**11 дүгээр зүйл.Нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргын эрх, үүрэг**

11.1.Нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга дараах эрх, үүрэгтэй:

11.1.1.цусны донорын үйлсийг сурталчлах, донор элсүүлэх, цусны донорыг алдаршуулах, урамшуулах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

11.1.2. харьяа эрүүл мэндийн байгууллагад гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэхэд шаардагдах нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэж, дэмжлэг үзүүлэх.

11.2.Энэ зүйлийн 11.1-д заасан үйл ажиллагааг Нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргын ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлтэд оруулан тооцно.

**12 дугаар зүйл. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан, ажил олгогчийн эрх, үүрэг**

12.1.Төрийн байгууллагын албан тушаалтан ажил олгогч нь дараах үүрэгтэй:

12.1.1.цусны донорын үйлсийг сурталчлах, донор элсүүлэх үйл ажиллагааг дэмжих;

12.1.2.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн донорт Хөдөлмөрийн тухай хуулийн 117.2-т заасан олговор олгох;

12.1.3.Төрийн албаны тухай хуулийн 13.1.4 -т хамаарах төрийн тусгай албан тушаалд ажилладаг цусны донорыг цусаа өгсөн өдөр нь энэ хуулийн 9.3.7, 17.1.6 -д заасан магадлагааг үндэслэн харуул, манаа, тусгай бэлтгэл сургуулилтаас чөлөөлөх;

12.2.Аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтан, ажил олгогч нь дараах үүрэгтэй:

12.2.1.цусны донорын үйл ажиллагааг дэмжих;

12.2.2.хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь цусны донорын талаар нийгэмд чиглэсэн ашгийн бус сурталчилгаа явуулах;

12.2.3.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн донорт энэ хуулийн 9.3.7, 17.1.4-т -д заасан магадлагааг үндэслэн чөлөө, Хөдөлмөрийн тухай хуулийн 117.2-т заасан олговор олгох.

12.3.Анагаах ухааны боловсрол олгох боловсролын байгууллага нь сургалтын хөтөлбөртөө цус сэлбэлт судлалын сургалтын агуулгыг тусгана.

**13 дугаар зүйл.Санхүүжилтийн тогтолцоо**

13.1.Цусны донорын үйл ажиллагааны санхүүжилт нь улсын болон орон нутгийн төсөв, эрүүл мэндийн даатгал, өөрийн орлого, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэний хандив, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

13.2. Энэ хуулийн 13.1-д заасан бусад эх үүсвэрт Эрүүл мэндийн тухай хуулийн 24.5 дахь хэсэгт заасан эх үүсвэрийг ойлгоно.

13.3.Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын өөрийн орлогоор Төсвийн тухай хуулийн 18.7-д заасны дагуу эргэлтийн сан байгуулах бөгөөд уг сангийн хөрөнгийг дараах зорилгоор ашиглаж болно.

13.3.1.цусны донорын үйлсийг сурталчлах, донорт элсүүлэх;

13.3.2.цусны донорыг алдаршуулах, урамшуулах;

13.3.3.цусны донорт хоол, илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүн олгоход дутагдсан зардал;

13.3.4.ажилтны нэмэгдэл цалин, урамшуулал, нийгмийн асуудлыг шийдвэрлэх;

13.3.5.эрдэм шинжилгээ, судалгааны төсөл хэрэгжүүлэх, тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн засвар, шинэчлэл хийх;

13.3.6.цус, сэлбэлт судлалын чиглэлээр эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах сургалт, дадлагад хамруулах.

13.4.Эргэлтийн сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журмыг Засгийн газар батална.

13.5.Цус, цусан бүтээгдэхүүний төлбөрийн жишиг хэмжээг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

13.6.Цус, сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төв, Цусны төвийн ажилтнуудад Төрийн албаны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуульд заасан нэмэгдлээс гадна сар бүр цусны албаны нэмэгдэл цалин олгоно.

13.7.Цусны албаны нэмэгдэл цалингийн хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## ЦУСНЫ ДОНОР, СЭЛБҮҮЛЭГЧ, ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА, АЖИЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

### 14 дүгээр зүйл.Цусны донорт тавигдах шаардлага

14.1.Хүний амь насыг аврах, эрүүл мэндийг сайжруулах, зорилгоор цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ сайн дураараа, авлагагүйгээр өгөх, цусны донорт тавигдах шалгуур үзүүлэлтийг хангасан хүн цусны донор болж болно.

14.2.Цусны донорыг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.

14.3.цусны донор сонгох асуумжтай танилцаж, өөрийн эрүүл мэндийн байдлыг үнэн зөвөөр мэдэгдэж, зөвшөөрсөн байна.

14.4.цусны донорт тавигдах эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

### 15 дугаар зүйл.Цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэгчид тавигдах шаардлага

15.1.Иргэн амь насаа аврах, эрүүл мэндийн байдлаа сайжруулах, эмчилгээний зорилгоор цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлж болно.

15.2.Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх зөвшөөрлийг иргэний эрх зүйн бүрэн чадамжтай сэлбүүлэгч өөрөө, хүүхэд болон эрх зүйн бүрэн чадамжгүй иргэний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч бичгээр өгсөн байна.

15.3.Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэхийг зөвшөөрөөгүй болон сэлбүүлэгч зөвшөөрөл өгөх, эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид мэдээлэх боломжгүй тохиолдолд холбогдох хууль, эмчилгээний зааврыг баримтлан Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1-д заасны дагуу мэргэжлийн баг шийдвэр гаргана.

### 16 дугаар зүйл.Цусны донорын үйл ажиллагаа болон цусны биобэлдмэлийн үйлдвэрлэлд оролцогч эмнэлгийн мэргэжилтэнд тавигдах шаардлага

16.1.Цусны донорт үзлэг хийх, цус, цусны бүрэлдэхүүн хэсэг авах, боловсруулах, хадгалах үйл ажиллагааг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх

зөвшөөрөл, цус, сэлбэлт судлалын чиглэлээр төрөлжсөн мэргэшил эзэмшсэн эмнэлгийн мэргэжилтэн гүйцэтгэнэ.

16.2.Цуглуулсан цусанд шинжилгээ хийх үйл ажиллагааг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, төрөлжсөн мэргэшил эзэмшсэн эмч, анагаах ухааны боловсрол олгодог боловсролын сургууль төгссөн эмнэлэгийн мэргэжилтэн гүйцэтгэнэ.

16.3.Цусны биобэлдмэлийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, төрөлжсөн мэргэшил эзэмшсэн эмч, анагаах ухааны боловсрол олгодог боловсролын сургууль төгссөн эмнэлэгийн мэргэжилтэн гүйцэтгэнэ.

**17 дугаар зүйл.Цусны донорын эрх, үүрэг**

17.1.Цусны донорын үүрэг гүйцэтгэж байгаа иргэн дараах эрх эдэлнэ:

17.1.1.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ сайн дураараа өгөх;

17.1.2. өөрийн эрүүл мэндэд учирч болох үр дагаварын талаар мэдээлэл авах, эрүүл мэндээ хамгаалуулах, сөрөг хариу урвал үүссэн тохиолдолд эмнэлгийн тусламж авах;

17.1.3.өөрийн шинжилгээний хариуг авах;

17.1.4.цусны донорын үүргээ гүйцэтгэх үедээ Хөдөлмөрийн тухай хуулийн 117.2-т заасан дундаж цалин хөлстэй тэнцэх олговор авах;

17.1.5.цусны донорын үйлсийг сурталчлах, эгнээг өргөжүүлэх ажилд сайн дураараа оролцох;

17.1.6.төрийн тусгай албан хаагч цусны донорын хувьд энэ хуулийн 12.1.3 -т заасан эрх эдлэх;

17.1.7.энэ хууль, бусад хууль тогтоомжоор тогтоосон дэмжлэг хүртэх.

17.2.Цусны донорын үүрэг гүйцэтгэж байгаа иргэн дараах үүрэгтэй:

17.2.1.иргэний үнэмлэх болон хувийн байдал тогтоох боломжтой бичиг баримтаа шалгуулах;

17.2.2.өөрийн эрүүл мэндийн талаар болон шаардлагатай бусад мэдээллийг үнэн зөвөгөх;

17.2.3.цус өгөхийн өмнө хийгдэх үзлэг, шинжилгээнд бүрэн хамрагдах;

17.2.4.эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийг мөрдөх.

17.3.Цусны донорын үүрэг гүйцэтгэх үедээ мэдэж байсан эрүүл мэндтэй холбоотой мэдээллээ нуусан, худал мэдээлснээс сэлбүүлэгчийн эрүүл мэнд, амь насанд аюул учруулсан, аюул учрах нөхцөл бий болгосон бол хуульд заасан хариуцлага хүлээнэ.

**18 дугаар зүйл.Цусны донорын үйл ажиллагаатай холбоотой эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг**

18.1.Эмнэлгийн мэргэжилтэн дараах эрх эдэлнэ:

18.1.1.иргэн, байгууллага, албан тушаалтанд мэргэжлийн зөвлөгөө өгөх, шаардлага тавих;

18.1.2.цусны донорыг танин тодруулах;

18.1.3.цусны донорт тэнцэх эсэх шийдвэр гаргах, Эрүүл мэндийн тухай хуулийн 28.1.3-д заасан тохиолдолд үйлчлэхээс татгалзах;

18.1.4.цусны донорын үүргээ гүйцэтгэсэн тухай магадлагаа олгох;

18.1.5.хууль тогтоомжид заасан бусад эрх.

18.2. Эмнэлгийн мэргэжилтэн дараах үүрэгтэй:

18.2.1.цусны донорын сургалт, сурталчилгааны ажлыг хэрэгжүүлэх;

18.2.2.цусны донорт учирч болзошгүй үр дагаварын талаар мэдээлэл өгөх;

18.2.3.цусны донор хүссэн тохиолдолд шинжилгээний хариутай холбоотой зөвлөгөө өгөх;

18.2.4.цус, цусны бүрэлдэхүүн хэсэг өгсөнтэй холбоотой урвал, хүндрэл үүссэн тохиолдолд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, яаралтай болон нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх шаардлагатай бол бусад эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх;

18.2.5.Цусны донорын мэдээллийг сэлбүүлэгчид, сэлбүүлэгчийн мэдээллийг цусны донорт мэдээлэхгүй байх, хүний эмзэг мэдээлэл, төрийн болон албаны нууцыг хамгаалах;

18.2.6.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## ЦУСНЫ ДОНОРЫН ҮЙЛСИЙГ СУРТАЛЧЛАХ, ДЭМЖИХ

**19 дүгээр зүйл.Цусны донорын үйлсийг сурталчлах, элсүүлэх**

19.1.Сайн дурын, авлагагүй цусны донорын хөдөлгөөнийг өрнүүлэх, сурталчлах ажлыг Монголын улаан загалмай нийгэмлэг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж хамтран зохион байгуулна.

19.2.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн нь цусны донорын сургалт, сурталчилгаа хийх,донор элсүүлэхэд цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

19.3.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь, цусны донорын талаарх ойлголт, ач холбогдлыг ерөнхий боловсролын сургуулийн ахлах анги болон их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгана.

19.4.Орон нутгийн төсөвт цусны донорын сургалт, сурталчилгаа, цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэхтэй холбоотой зардлыг тусгана.

19.5. Цусны донорын үйлсийг сурталчлах, эгнээг өргөжүүлэх үйл ажиллагаанд сайн дурын ажилтныг оролцуулж болно.

**20 дугаар зүйл.Цусны донорыг алдаршуулах, урамшуулах**

20.1.Цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ 50 болон түүнээс дээш, цусаа 35 болон түүнээс дээш, ховор бүлгийн цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ 25 болон түүнээс дээш удаа өгсөн цусны донорыг Монгол Улсын Засгийн газрын шагнал Цусны хүндэт донор хүндэт тэмдгээр шагнаж, алдаршуулна.

20.2.Цусны донорыг алдаршуулах, урамшуулах зорилгоор эд материал, санхүүгийн дэмжлэг, тусламжийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага үзүүлж болно.

**21 дүгээр зүйл.Цусны донорт үзүүлэх дэмжлэг**

21.1.Цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн донорт илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүн, эсхүл хоолоор үйлчилнэ.

21.2.Энэ зүйлийн 21.1-д заасан дэмжлэг үзүүлэх боломжгүй бол энэ хуулийн 8.1.5-д заасан жишиг хэмжээтэй адил хэмжээний мөнгөн дэмжлэг олгоно.

21.3.Засгийн газрын шагнал Цусны Хүндэт донор тэмдгээр шагнагдсан донорт дараах дэмжлэг үзүүлнэ:

21.3.1.нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй зорчих;

21.3.2.эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамрагдах;

21.3.3.магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд жилд нэг удаа үнэ төлбөргүй сувилуулах;

21.3.4.шаардлагатай тохиолдолд үнэ төлбөргүй цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэх.

21.4.Энэ хуулийн 21.3-т заасан дэмжлэгийг Ахмад настны тухай хууль, бусад хууль тогтоомжоор тогтоосон дэмжлэгтэй давхардуулан олгохгүй.

21.5.Цусны байнгын донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд жилд нэг удаа үнэ төлбөргүй сувилуулах журмыг

хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална.

21.6.БНМАУ-ын Хүндэт донор, МУЗН-ийн Хүндэт донор энгэрийн тэмдэгтэй иргэдэд дээрх дэмжлэг мөн адил хамаарна.

## ТАВДУГААР БҮЛЭГ

## ДОНОРООС ЦУС, ЦУСНЫ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ ЦУГЛУУЛАХ, ШИНЖЛЭХ, БОЛОВСРУУЛАХ, ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ХЭРЭГЛЭХ

**22 дугаар зүйл.Цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, хэрэглэх**

22.1.Цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллага хэрэгжүүлнэ.

22.2.Энэ зүйлийн 22.1-д заасан тусгай мэргэжлийн төв хөдөлгөөнт иж бүрдэлтэй байна.

22.3.Цус, цусан бүтээгдэхүүний тээвэрлэлтийг цусны донорын үйл ажиллагаанд оролцогч эрүүл мэндийн байгууллага гүйцэтгэж болно.

22.4.Алслагдсан сумын эрүүл мэндийн төвд эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх тохиолдолд, эрх бүхий байгууллагаас тогтоосон шаардлагын дагуу цус цуглуулж, шинжилж, сэлбэж болно.

22.5.Тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллага эмчилгээний зорилгоор цус, цусан бүтээгдэхүүн хэрэглэнэ.

22.6.Энэ зүйлийн 22.5 дахь хэсэгт заасан байгууллага нь цус, цусан бүтээгдэхүүн сэлбэлттэй холбоотой урвал, хүндрэл үүссэн тохиолдлыг цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төвд мэдээлнэ.

22.7.Эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаа хэрэгжүүлэх эрх бүхий эрүүл мэндийн байгууллага, анагаах ухааны боловсрол олгох боловсролын байгууллагын эмнэлэг цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг судалгаа, шинжилгээний зорилгоор хэрэглэнэ.

22.8.Цус, цусны бүрэлдэхүүн хэсэг, цус, цусан бүтээгдэхүүнийг эмчилгээний бус зорилгоор хэрэглэхийг хориглоно.

**23 дугаар зүйл.Донорын цус, цусан бүтээгдэхүүн, биобэлдмэлийг улсын хилээр нэвтрүүлэх**

23.1.Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу чанар, аюулгүй байдлын хувьд баталгаажсан цус, цусан бүтээгдэхүүн, биобэлдмэлийг экспортлож, импортлож болно.

23.2.Цус, цусан бүтээгдэхүүн, биобэлдмэлийг улсын хилээр нэвтрүүлэх журмыг Засгийн газар батална.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ
## ГАМШИГ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ХАРИЛЦАА

**24 дүгээр зүйл.Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн зохицуулалт**

24.1.Гамшиг, аюулт үзэгдэл, осол, цар тахал болон бусад онцгой байдлын үед цус, цусны бүрэлдэхүүн хэсэг цуглуулах зохион байгуулалтыг улсын хэмжээнд гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын алба, тодорхой нутаг дэвсгэрт гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед цус, цусны бүрэлдэхүүн хэсэг цуглуулах зохион байгуулалтыг орон нутгийн онцгой комиссын шийдвэрийн дагуу хийнэ.

24.2.Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгөх боломжтой хүн амын дунд сурталчилгаа явуулах, тэднээс цус цуглуулах үйл ажиллагаатай холбоотой зохион байгуулалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу хэрэгжүүлнэ.

24.3.Энэ хуулийн 12.3-т заасан хөтөлбөрт бүрэн хамрагдсан оюутан, цус сэлбэлт судлалын чиглэлээр мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтэн, нийг энэ хуулийн 24.1-д заасан тохиолдолд цусны донорын үйл ажиллагаанд татан оролцуулж, ажиллуулж болно.

24.4.Энэ хуулийн 24.1-д заасан тохиолдолд үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын бие бүрэлдэхүүн, болон бусад төрийн албан хаагчдаас цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлж болно.

24.5.Энэ хуулийн 24.4-т заасан үйл ажиллагаанд хамрагдсан цусны донорт өгөх илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүнийг тухайн цусны донорын харьяалагдах байгууллага олгоно.

24.6.Энэ хуулийн 24.1, 24.3, 24.5-д заасантай холбоотой зардлыг Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлнэ.

## ДОЛООДУГААР БҮЛЭГ
## ЦУСНЫ ДОНОРЫН МЭДЭЭЛЛИЙН САН

**25 дугаар зүйл.Цусны донорын мэдээллийн сан**

25.1.Цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, түүнд хяналт тавих зорилгоор цусны донорын мэдээллийн санг үүсгэж, баяжуулна.

25.2.Цусны донорын мэдээллийн сангийн журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн болон цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

25.3.Энэ зүйлийн 25.1-д заасан мэдээллийг төрийн мэдээллийн нэгдсэн сангаас авч болно.

25.4.Цусны донорын мэдээллийн сан төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр цусны төв, цус, цусан бүтээгдэхүүн хэрэглэгч эрүүл мэндийн байгууллагуудтай холбогдсон байна.

25.5.Энэ хуулийн 25.1-д заасан мэдээллийг судалгааны зорилгоор ашиглах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах дотоод журмыг цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага батлан мөрдүүлнэ.

## НАЙМДУГААР БҮЛЭГ
## ХАРИУЦЛАГА

### 26 дугаар зүйл.Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих

26.1.Цусны донорын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын болон холбогдох бусад байгууллага хяналт тавина.

### 27 дугаар зүйл.Цусны донорын үйл ажиллагааны журмыг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

27.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

27.2. Энэ хуулийг зөрчсөнөөс хүний амь нас хохирсон, эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, учрах нөхцөл бүрдүүлсэн бол холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ
## БУСАД ЗҮЙЛ

### 28 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

28.1.Энэ хууль хүчин төгөлдөр дагаж мөрдөхөөс өмнө аймгийн нэгдсэн эмнэлэгт харьяалагдаж байсан цусны салбар төв, нийслэлийн эрүүл мэндийн асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төвийн харьяанд байсан цусны биобэлдмэл үйлдвэрлэх нэгжийг орон тоо, төсөв, хөрөнгийн хамт цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төвийн харьяанд тус тус шилжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулна.

28.2.Энэ хуулийн 28.1-д заасан үйл ажиллагааг зохион байгуулагдаж дуусах хүртэл хугацаанд урьд хүчин төгөлдөр мөрдөж байсан хуулийг дагаж мөрдөнө.

### 29 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

29.1.Энэ хуулийг 2025 оны ... дугаар сарын ....-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

---oOo---

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2025 оны ... дүгээр сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

## АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд дор дурьдсан агуулгатай 15 дугаар зүйлийн 15.1.15 дахь заалт нэмсүгэй:

"15.1.15.Цусны донорын үйл ажиллагааг дэмжих зорилгоор өгсөн 10 сая хүртэлх төгрөгийн хандив."

**2 дугаар зүйл.** Энэ заалтыг Цусны донорын тухай хууль батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2025 оны ... дүгээр сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

## ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн Зургадугаар бүлгийн 6.10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7 дугаар хэсэг нэмсүгэй:**

**"7.** Цусны донорын үүрэг гүйцэтгэх үедээ мэдэж байсан эрүүл мэндтэй холбоотой мэдээллээ нуусан, худал мэдээлснээс сэлбүүлэгчийн эрүүл мэнд, амь насанд аюул учрах нөхцөл бий болгосон бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Цусны донорын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дүгээр сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

## ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Эрүүгийн хуулийн Арван тавдугаар бүлгийн 15.4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 2 дугаар хэсэг нэмсүгэй:

"2. Цусны донорын үүрэг гүйцэтгэх үедээ мэдэж байсан эрүүл мэндтэй холбоотой мэдээллээ нуусан, худал мэдээлснээс сэлбүүлэгчийн эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хохирогч нас барсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Цусны донорын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дүгээр сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

## ДОНОРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Дөрөвдүгээр бүлгийн нэрийг “Донороос эс, эд, эрхтэн авах, шинжлэх, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах, устгах” гэж, 19 дүгээр зүйлийн нэрийг “Донороос эс, эд, эрхтнийг эмчилгээний зориулалтаар авах, шинжлэх, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах, устгах” гэж, 20 дугаар зүйлийн нэрийг “Донорын эс, эд эрхтнийг улсын хилээр нэвтрүүлэх” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Донорын тухай хуулийн 1 дүгээр зүлийн 1.1 дэх хэсгийн , 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн 10.1.1 дэх заалтын, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн 13.1.1 дэх заалтын, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн 13.1.4 дэх заалтын, , 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “цус,” гэснийг, 1 дүгээр зүлийн 1.1 дэх хэсгийн “,цусны аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагаа” гэснийг, 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль,” гэснийг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “,цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэх” гэснийг, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 6.1.1 дэх заалтын, мөн зүйлийн мөн хэсгийн 6.1.3 дахь заалтын 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн 7.1.2 дахь заалтын, мөн зүйлийн мөн хэсгийн 7.1.3 дахь заалтын, мөн зүйлийн мөн хэсгийн 7.1.5 дахь заалтын “цусны аюулгүй байдал,” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “Донорын цус, цусан бүтээгдэхүүн болон” гэснийг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн 13.1.3 дахь заалтын “цус сэлбүүлэх,” гэснийг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн 13.1.3 дахь заалтын “донор цус сэлбэсэн,” гэснийг, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэх,” гэснийг, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх,” гэснийг, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “цус, цусан бүтээгдэхүүн,” гэснийг, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “цус, цусан бүтээгдэхүүнийг экспортолж, импортолж” гэснийг тус тус хассугай

**3 дугаар зүйл.** Донорын тухай хуулийн Тавдугаар бүлгийг, 8 дугаар зүйлийг, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3.1.5 дахь заалтыг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3.1.6 дахь заалтыг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3.1.7 дахь заалтыг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3.1.8 дахь заалтыг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3.1.9 дэх заалтыг, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 6.1.4 дэх заалтыг, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн 13.1.6 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

# ЦУСНЫ ДОНОРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД
# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ӨГСӨН САНАЛ

| Д/д | Хуулийн зүйл, хэсэг заалт | Гарсан санал | Санал гаргасан этгээд | Санал тусгагдсан эсэх |
|---|---|---|---|---|
| 1 | 1.1.Энэ хуулийн зорилт нь цусны донорын үйл ажиллагаатай холбоотой төрийн бодлого, зохицуулалт, баримтлах зарчим, тэдгээрийг хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн үндэс, удирдлага, санхүүжилтийн тогтолцоо, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэний нийтлэг эрх, үүрэг, цус сэлбэлт судлалын албанд ажиллагсадын цалин, хөлс, нийгмийн баталгаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. | Донорын тухай хуулиар хүний эрүүл мэндийг хамгаалах, амь насыг нь аврах зорилгоор сайн дураараа цус, эс, эд, эрхтнээ үнэ төлбөргүй өгөх, шилжүүлэн суулгах, цусны аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагаа болон уг үйл ажиллагааны талаархи төрийн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэний эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулахаар заасан.<br>Харин Цусны донорын тухай хуулийн төсөлд цусны донорын үйл ажиллагаатай холбоотой төрийн бодлого, зохицуулалт, баримтлах зарчим, түүнийг хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн үндэс, санхүүжилтийн тогтолцоо, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэний эрх, үүрэг, цус сэлбэлт судлалын албанд ажиллагсадын цалин, хөлс, нийгмийн баталгаатай холбогдсон харилцааг зохицуулахаар тусгасан нь дээрх Донорын тухай хуулиар зохицуулах хүний цус, эд, эс, | Монгол Улсын Засгийн газар | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | эрхтний донортой холбоотой бүхий л үйл ажиллагааг цогц байдлаар зохицуулсан харилцаатай давхардаж байна.<br>Иймд цусны донортой холбоотой харилцааг Донорын тухай хуулиас салган тусгайлсан хуулиар зохицуулах болсон үндэслэл, шаардлагыг дахин нягтлах нь зүйтэй байна. | | |
| 2 | **10 дугаар зүйл. Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг**<br>10.1.Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.12-д заасан тусгай мэргэжлийн төв байх бөгөөд мөн хуулийн 16.15-д заасан эрх, үүргээс гадна дараах эрх, үүрэгтэй:<br>10.1.1.цусны донорын сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжил, арга зүйгээр хангах, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулах;<br>10.1.2.цусны донорт эрүүл мэндийн үзлэг хийх, сонгох;<br>10.1.3.цуглуулсан цус, түүний бүрэлдэхүүн хэсэгт цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх, цусны бүлэг тодорхойлох, бүтээгдэхүүний чанарын баталгаа хангах болон бусад шинжилгээ хийх; | Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд зааснаар хуулийн төслийн агуулга Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байхыг шаарддаг. Гэтэл хуулийн төслийн 10 дугаар зүйлд заасан Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын чиг үүрэг нь 11 дүгээр зүйлд заасан Цусны төвийн чиг үүрэгтэй давхардаж байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.2-т чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоохгүй байхаар заасантай нийцэхгүй байна.<br>Түүнчлэн хуулийн төслийн 15.3-т цусны донорын үйлсийг сурталчлах, элсүүлэхэд санхүү, эд материалын дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгж байгууллагын тухайн үйл ажиллагаанд | Монгол Улсын Засгийн газар | **10 дугаар зүйл. Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг**<br>10.1.Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.12-д заасан тусгай мэргэжлийн төв байх бөгөөд мөн хуулийн 16.15-д заасан эрх, үүргээс гадна дараах эрх, үүрэгтэй:<br>10.1.1.цусны донорын сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжил, арга зүйгээр хангах, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулах;<br>10.1.2.цусны донорт эрүүл мэндийн үзлэг хийх, сонгох;<br>10.1.3.цуглуулсан цус, түүний бүрэлдэхүүн хэсэгт цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх, цусны бүлэг тодорхойлох, бүтээгдэхүүний чанарын баталгаа хангах болон бусад шинжилгээ хийх; |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 10.1.4.цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг боловсруулж, цус, цусан бүтээгдэхүүн, цусны бэлдмэл үйлдвэрлэх;<br><br>10.1.5.цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн тогтвортой байдлыг хангах;<br><br>10.1.6.донорт цусаа бэлэглэсэн талаарх магадлагаа олгох;<br><br>10.1.7.цусны донорыг алдаршуулах, урамшуулах үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулах;<br><br>10.1.8.олон удаа цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ бэлэглэсэн цусны донорыг шагнах, Засгийн газрын болон төрийн шагналд нэр дэвшүүлэх;<br><br>10.1.9.цусны чанар, аюулгүй байдал, цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээ, цусны сонор сэрэмжийн тогтолцоог үндэсний хэмжээнд удирдлага зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангах;<br><br>10.1.10.цусны донорын үйл ажиллагаа, | зарцуулсан 10 сая хүртэл төгрөгийг цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөхөөр тусгасан нь Татварын ерөнхий хуулийн 4.1-д татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгохоор, 4.2-т татварыг хөнгөлөхтэй холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн төсөвтэй хамт боловсруулахаар заасантай зөрчилдөж байна.<br>Мөн хуулийн төслийн 15.5, 15.7 дахь хэсэгт Цус, сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төв, Цусны төвийн ажилтнуудад Төрийн албаны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуульд заасан нэмэгдлээс гадна сар бүр цусны албаны нэмэгдэл цалин олгохоор нэмэгдэл цалингийн хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар тогтоохоор тусгасан нь Төрийн албаны тухай хуулийн 57.8-д "үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдэл, бусад нэмэгдэл хөлсний доод хэмжээг | | 10.1.4.цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг боловсруулж, цус, цусан бүтээгдэхүүн, цусны бэлдмэл үйлдвэрлэх;<br><br>10.1.5.цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн тогтвортой байдлыг хангах;<br><br>10.1.6.донорт цусаа бэлэглэсэн талаарх магадлагаа олгох;<br><br>10.1.7.цусны донорыг алдаршуулах, урамшуулах үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулах;<br><br>10.1.8.олон удаа цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ бэлэглэсэн цусны донорыг шагнах, Засгийн газрын болон төрийн шагналд нэр дэвшүүлэх;<br><br>10.1.9.цусны чанар, аюулгүй байдал, цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээ, цусны сонор сэрэмжийн тогтолцоог үндэсний хэмжээнд удирдлага зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангах;<br><br>10.1.10.цусны донорын үйл ажиллагаа, [illegible] ашиглах техник, технологийн сонголт, шинэчлэл хийх; |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | ашиглах техник, технологийн сонголт, шинэчлэл хийх;<br><br>10.1.11.цусны донорын мэдээллийн сангийн бүрдүүлэлт, өөрчлөлт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хариуцах талаар хууль, тогтоомжоор тогтоосон үүргийг хэрэгжүүлэх;<br><br>10.1.12.цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хэрэглээ, нөөц, хангамжийг зохицуулах, хадгалах, хянах, мэдээ, тайланг улсын хэмжээнд нэгтгэн гаргах, холбогдох байгууллагад хүргүүлэх.<br><br>10.2. Цус, сэлбэлт судлалын тусгай мэргэжлийн төвийн харьяанд Цусны төв болон [illegible] байгуулж болно.<br><br>[illegible]<br><br>10.4. Цусны төв болон [illegible] бүтэц, дүрмийг Эрүүл мэндийн | хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно" гэж заасантай нийцэхгүй байна.<br>Өөрөөр хэлбэл дээр дурьдсан мэргэжлийн төвийн ажилтнууд нь Төрийн албаны тухай хуулийн 14.1.2-т заасан төрийн үйлчилгээний албан тушаалд хамаарах тул Төрийн албаны тухай хуульд заасан цалин, хөлс, нэмэгдлээс бусад цалин, нэмэгдэл, урамшууллыг тусгайлсан хуулиар олгохгүй болохыг анхаарах нь зүйтэй байна.<br>Хуулийн төслийн 18.1.9-д ажиллаж байгаа байгууллагын удирдлагатай тохиролцсоны дагуу хүссэн үедээ цусаа бэлэглэх, цус өгсөн өдрөө цалинтай чөлөө авах, чөлөөлөөгүй тохиолдолд тухайн өдрийн цалингаа нэг аравны тав дахин өсгөж авахаар тусгасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 117.2-т донорын үүрэг гүйцэтгэх хугацаанд ажилтанд дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговор олгохоор заасантай зөрчилдөж байна.<br>Түүнчлэн хуулийн төслийн 24.2.3-т магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд жилд нэг удаа үнэ төлбөргүй | | 10.1.11.цусны донорын мэдээллийн сангийн бүрдүүлэлт, өөрчлөлт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хариуцах талаар хууль, тогтоомжоор тогтоосон үүргийг хэрэгжүүлэх;<br><br>10.1.12.цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хэрэглээ, нөөц, хангамжийг зохицуулах, хадгалах, хянах, мэдээ, тайланг улсын хэмжээнд нэгтгэн гаргах, холбогдох байгууллагад хүргүүлэх.<br><br>10.3. [illegible]ус, сэлбэлт судлалын тусгай мэргэжлийн төвийн харьяанд Цусны төв [illegible] байгуулж болно<br><br>[illegible]<br><br>10.4. Цусны төв болон [illegible] бүтэц, дүрмийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн Газрын гишүүн батална. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | асуудал эрхэлсэн Засгийн Газрын гишүүн батална. | сувилуулах дэмжлэгийг Засгийн газрын шагнал болох Монгол Улсын хүндэт донор тэмдэгээр шагнагдсан цусны донорт олгохоор тусгасан нь Донорын тухай хуулийн 22.1-д цусаа 35-аас дээш удаа өгсөн донорыг магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд жилд нэг удаа үнэ төлбөргүй сувилуулах зохицуулалттай зөрчилдөж байгааг анхаарах нь зүйтэй байна. | | |
| 3 | **11 дүгээр зүйл. Цусны төвийн эрх, үүрэг**<br>11.1.Цусны төв дараах эрх, үүрэгтэй:<br><br>11.1.1.цусны донорын сургалт, сурталчилгааг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулах;<br><br>11.1.2.цусны донорт эрүүл мэндийн үзлэг хийх, сонгох;<br><br>11.1.3.цусны донороос цус, түүний бүрэлдэхүүн хэсэг авах, түүнд цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх, бүлэг тодорхойлох болон бусад шинжилгээ хийх;<br><br>11.1.4.цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг боловсруулж, цус, цусан бүтээгдэхүүн, [illegible] үйлдвэрлэх;<br><br>11.1.5.орон нутгийн хэмжээнд цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн тогтвортой байдлыг хангах; | | | Хассан |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 11.1.6.орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад цус сэлбэлт судлалын чиглэлээр мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;<br><br>11.1.7.донорт цусаа бэлэглэсэн талаарх магадлагаа олгох;<br><br>11.1.8.цусны донорыг алдаршуулах, урамшуулах үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулах;<br><br>11.1.9.олон удаа цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ өгсөн цусны доноруудыг цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төвд уламжлан Засгийн газрын болон төрийн шагнал, бусад шагналд нэр дэвшүүлэх;<br><br>11.1.10.цус, цусан бүтээгдэхүүн, хэрэглээ, нөөц, хангамжийг орон нутгийн хэмжээнд зохицуулах, хадгалах, хянах, мэдээ, тайланг нэгтгэн, цус, сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төвд хүргүүлэх.<br><br>11.2.Цусны төв, [illegible] нь цус сэлбэлт судлалын тусгай мэргэжлийн төвийн харьяанд, эсхүл аймаг, сумын | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Нэгдсэн эмнэлгийн дэргэд бие даасан хэлбэртэй байж болно.<br><br>11.3.Цусны төвийн бүтэц, орон тооны дээд хязгаарыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.<br><br>11.4.Цусны төвийн цуглуулсан цусны нэгж бүрт цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээг холбогдох эрүүл мэндийн байгууллага хийнэ. | | | |
| 4 | 15.3.Цусны донорын үйлсийг сурталчлах, элсүүлэхэд санхүү, эд материалын дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгж байгууллагын тухайн үйл ажиллагаанд зарцуулсан цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлнө. | | | Хассан+++ |
| 5 | 15.5.Цус, сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төв, Цусны төвийн ажилтнуудад Төрийн албаны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуульд заасан нэмэгдлээс гадна сар бүр цусны албаны нэмэгдэл цалин олгоно. | | | “57.2.4.үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс тус тус бүрдэнэ.”, “57.8.Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдэл, бусад нэмэгдэл хөлсний доод хэмжээг хөдөлмөрийн |
| 6 | 15.7.Цусны албаны нэмэгдэл цалингийн хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | гишүүний саналыг үндэслэн Засгийн газар тогтооно. | | | асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно." Гэж заасан байдаг бөгөөд бусад нэмэгдлийг хуульд тусган Засгийн газар тогтооход зөрчил үүсэхгүй. Эрүүл мэндийн даатгалаас санхүүждэггүй байгууллагын хувьд өөр байдлаар салбарын ажилтнуудын цалин, хөлсийг нэмэгдүүлэх боломжгүй байна.<br>Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн болон орон нутаг дахь Цусны салбар төвийн ажилтнуудаас Донорын хууль өнөөгийн шаардлагад нийцэж байгаа эсэх, цаашид зохицуулах шаардлагатай асуудал зэргээр авсан судалгаа авч дүгнэсэн. Судалгаагаар Цус сэлбэлт судлалын үндэсний төв тусгай мэргэжлийн төвийн хувьд улсын төсвөөс санхүүжиж байхад Цусны салбар төвүүд Орон нутгийн нэгдсэн эмнэлэгт харьяалагдаж Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжихээр болж байгаагаас Цусны салбар төвийн мэргэжилтнүүдэд орон тоо, цалин, хөлстэй холбоотой хүндрэл үүсэх, хүний нөөцийн тогтвортой байдал алдагдах, зарим Цусны салбар төвийн өрөө, тасалгааг өөр зорилгоор ашиглахаар шилжүүлсэн гэх асуудал ч гарах болсон нь зөвхөн цус сэлбэлт судлалын салбарт ч биш эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд сөрөг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | нөлөө үзүүлэх хүчин зүйл болж болзошгүй байгаа юм. Иймээс цус сэлбэлт судлалын салбарт ажилладаг эрүүл мэндийн ажилтнуудыг урамшуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх, тэдний нийгмийн асуудлыг дэмжих асуудал тулгамдаж байна. Цалин, хөлсийг нэмэгдүүлэхгүй тохиолдолд:<br>1. Зөвхөн нэг чиглэлээр ажилладагаас шалтгаалан сурах, боловсрох, хөгжих боломж муу гэж үзэн эмнэлгийн мэргэжилтнүүд ажиллах сонирхол бага болсон<br>2. Бусад эрүүл мэндийн байгууллагаас бага цалинтайгаас хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад шилжих, бусад бизнесийн байгууллагад шилжих хөдөлгөөн жил бүр нэмэгдэж байгаа<br>3. Төлбөрт болон бусад үйлчилгээ үзүүлэн нэмэлт орлого олох боломжгүйгээс нэмэгдэл хөлс олох боломжгүй<br>Тайлбар нэмэх+++ |
| 7 | 18.1.9. ажиллаж байгаа байгууллагын удирдлагатай тохиролцсоны дагуу хүссэн үедээ цусаа бэлэглэх, цус өгсөн өдрөө цалинтай чөлөө авах, чөлөөлөөгүй тохиолдолд тухайн өдрийн цалингаа нэг аравны тав дахин өсгөж авах; | | | Хассан |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8 | 24.2.3.магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд жилд нэг удаа үнэ төлбөргүй сувилуулах; | | | Тайлбар |
| 9 | 16.1.Хүний эрүүл мэндийг хамгаалах, амь насыг аврахад зориулан цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ сайн дурын үндсэн дээр, авлагагүйгээр өгөх хүсэлтэй, эрүүл мэндийн хувьд харшлах шалтгаангүй, иргэний эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын иргэн, Монгол Улсад зургаан сараас багагүй хугацаанд байнга оршин сууж байгаа гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн цусны донор болж болно. | Хуулийн төслийн 16.1-д гадаадын иргэн, харьяалалгүй хүн цусны донор болохын тулд Монгол Улсад зургаан сараас багагүй хугацаанд байнга оршин суусан байх шалгуурыг тавих болсон үндэслэл, шаардлага тодорхойгүй байх тул зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд хуулийн төсөлд хүнийг ялгаварлан гадуурхах зохицуулалт оруулахгүй байх ёстойг анхаарах. | Монгол Улсын Засгийн газар | Тодорхой газарзүйн бүс нутагт мэдэгдэж байгаа болон мэдэгдэхгүй шинэ халдвараас сэргийлэх, халдварын далд үеийн эрсдэлээс сэрийлэх зорилгоор уг хугацааг тогтоосон.<br>Жишээ нь: хумхаа нутагшмал гардаг гэх мэт<br>Хугацааг ЭМС гэх мэт+++ |
| 10 | 15.2.Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын өөрийн орлогоор Төсвийн тухай хуулийн 18.7-д заасны дагуу эргэлтийн сан байгуулах бөгөөд уг сангийн хөрөнгийг дараах зорилгоор ашиглаж болно:<br>15.2.1.цусны донорын үйлсийг сурталчлах, донорт элсүүлэх;<br>15.2.2.цусны донорыг алдаршуулах, урамшуулах;<br>15.2.3.цусны донорт илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүн олгох;<br>15.2.4.цус, сэлбэлт судлалын чиглэлээр эмнэлгийн мэргэжилтнийг гадаад оронд | Хуулийн төслийн 15.2-т цусны донорын үйлсийг сурталчлах, цусны донорыг урамшуулах, цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төв, цусны төвийн ажилтны нэмэгдэл цалин, урамшуулал зэрэг нийгмийн асуудлыг шийдвэрлэх эргэлтийн санг бүрдүүлэх эх үүсвэр тодорхой байх, дунд хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах, төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөвт хөтөлбөр хэлбэрээр тусган хэрэгжүүлэх боломжгүй байх, бусад тусгай сангийн үйл ажиллагаатай давхардаагүй байх, холбогдох тооцоо, судалгаанд үндэслэсэн | Монгол Улсын Засгийн газар | Судалгаагаар Цус сэлбэлт судлалын үндэсний төв тусгай мэргэжлийн төвийн хувьд улсын төсвөөс санхүүжиж байхад Цусны салбар төвүүд Орон нутгийн нэгдсэн эмнэлэгт харьяалагдаж Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжихээр болж байгаагаас Цусны салбар төвийн мэргэжилтнүүдэд орон тоо, цалин, хөлстэй холбоотой хүндрэл үүсэх, хүний нөөцийн тогтвортой байдал алдагдах, зарим Цусны салбар төвийн өрөө, тасалгааг өөр |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | төгсөлтийн дараах сургалт, дадлагад хамруулах;<br><br>15.2.5.эрдэм шинжилгээ, судалгааны төсөл хэрэгжүүлэх, техникийн болон мэдээллийн технологийн засвар, шинэчлэл хийх;<br><br>15.2.6.цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төв, цусны төвийн ажилтны нэмэгдэл цалин, урамшуулал, нийгмийн асуудлыг шийдвэрлэх. | байх зэрэг шаардлагад нийцэх эсэхийг нягтлах нь зүйтэй. | | зорилгоор ашиглахаар шилжүүлсэн гэх асуудал ч гарах болсон нь зөвхөн цус сэлбэлт судлалын салбарт ч биш эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйл болж болзошгүй байгаа юм. Иймээс цус сэлбэлт судлалын салбарт ажилладаг эрүүл мэндийн ажилтнуудыг урамшуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх, тэдний нийгмийн асуудлыг дэмжих асуудал тулгамдаж байна.<br>Цусны доноруудаас авсан судалгаагаар цусны байнгын донорт дэмжлэг үзүүлэх, тэдний эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, халамжийн асуудлыг сайжруулах, цус өгсөн донорыг илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүнээр үйлчлэх, хүн амын дунд ялангуяа оюутан, сурагчдад цусны донорын нийгмийн ач холбогдлыг таниулсан сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх, цусны донорын үйл ажиллагааг дэмжин хамтран ажилласан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулах, цусны донорын үйл ажиллагааг дэмжин зарцуулсан зардлыг нь татвараас |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | чөлөөлөх зэрэг цусны нөөц хангамжийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчин бий болгох, үндэсний аюулгүй байдалтай холбоотой онцлог салбарын хувьд төрөөс цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн талаар онцгойлон анхаарах шаардлагатай байна |
| 11 | 18.3.Цусны донорын үүрэг гүйцэтгэх үедээ мэдэж байсан эрүүл мэндтэй холбоотой мэдээллээ нуусан, худал мэдээлснээс сэлбүүлэгчийн эрүүл мэнд, амь насанд аюул учруулсан, аюул учрах нөхцөл бий болгосон бол хуульд заасан хариуцлага хүлээнэ. | Хуулийн төслийн 18.3-т цусны донорын үүрэг гүйцэтгэх үедээ мэдэж байсан эрүүл мэндтэй холбоотой мэдээллээ нуусан, худал мэдээлснээс сэлбүүлэгчийн эрүүл мэнд, амь насанд аюул учруулсан, аюул учрах нөхцөл бий болгосон бол хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр тусгасан боловч дээрх агуулгатай уялдуулан хариуцлагын арга хэмжээг Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдан боловсруулаагүй байгааг анхаарах. | Монгол Улсын Засгийн газар | Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл бэлдсэн |
| 12 | 14.1.6.цэрэг, цагдаагийн албан хаагч цусны донорыг цусаа өгсөн өдөр нь энэ хуулийн 10.1.6, 11.1.7-д заасан магадлагааг үндэслэн харуул, манаа болон цэргийн албаны бусад үүрэг гүйцэтгэхээс чөлөөлөх;<br><br>14.1.7.цэрэг, цагдаагийн албан хаагч цусны донорт цусаа | Хуулийн төслийн үзэл баримтлалд Донорын тухай хуулийг хүчингүй болгохоор тусгасан боловч Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсныг анхаарч, хэрэв Донорын тухай хуулийг хүчингүй болгосон тохиолдолд цусны донороос | Монгол Улсын Засгийн газар | 14.1.6.Төрийн албаны тухай хуулийн 13.1.4 дэх заалтад хамаарах төрийн тусгай албан тушаалд ажилладаг цусны донорыг цусаа өгсөн өдөр нь энэ хуулийн 10.1.6, 11.1.7-д заасан магадалгааг үндэслэн харуул, манаа, тусгай бэлтгэл сургуулиас чөлөөлөх; |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | бэлэглэсэн өдөрт нь энэ хуулийн 10.1.6, 11.1.7-д заасан магадлагаа үндэслэн чөлөө, Хөдөлмөрийн тухай хуулийн 117.2-т заасан олговор олгох, алдаршуулах, урамшуулах; | гадна хүний эс, эд, эрхтний донортой холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн орчингүй болох, хийдэл үүсэх сөрөг үр дагавар бий болохыг анхаарах нь зүйтэй.<br>Мөн хуулийн төслийн 14.1.6, 14.1.7, 18.1.10-т төрийн цэргийн болон цагдаагийн байгууллагын албан хаагчийг цусаа өгсөн өөр магадалгааг үндэслэн харуул, манаа болон цэргийн албаны бусад үүрэг гүйцэтгэхээс чөлөөлөх, хууль тогтоомжид заасан олговор олгохоор тусгасан байна.<br>Донорын тухай хуулийн 3.1.5-д “цусны донор”-ыг хүний эрүүл мэндийг хамгаалах, амь насыг аврахад зориулсан сайн дураар цусаа өгөгч гэж тодорхойлсон бөгөөд харин хуулийн төсөлд цусны донороос төрийн цэргийн болон цагдаагийн алба хаагчийг тусгайлан авч үзэж байгаа үндэслэл, шаардлага тодорхойгүй байгааг анхаарах нь зүйтэй. | | 14.1.7.Төрий[illegible] цусаа бэлэглэс[illegible] [illegible] 10.1.6, 11.[illegible] магадлалгаа үндэслэн [illegible] [illegible] 117.2-[illegible] [illegible] алд[illegible]уулах, ура[illegible]; |
| 13 | 18.1.10.цэргийн албан хаагч цусны донорын хувьд цус өгсөн өдөр харуул, манаа, цэргийн албаны бусад үүрэг гүйцэтгэхээс чөлөөлөгдөх; | | | 18.1.10.төрийн тусгай албан хаагч цусны донорын хувьд энэ хуулийн 14.1.6, 14.1.7 –д заасан эрх эдлэх; |
| 14 | 3.1.3.“бүхэл цус” гэж уламжлалт аргаар авч байгаа цусыг; | Цусны донорын тухай хуулийн төсөл болн дагалдан боловсруулсан хуулийн төслүүд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцэхгүй байна. | Монгол Улсын Засгийн газар | 3.1.3.“бүхэл цус” гэж бүрдэл хэсгийг нь салгалгүйгээр цуглуулсан цусыг ; |
| 15 | 5.2.1.эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас цус, сэлбэлт судлалын чиглэлээр үйл ажиллагаа | | | 5.2.1.эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас цус, сэлбэлт |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | явуулах эрх олгох зөвшөөрлийн хяналт; | Тухайлбал, хуулийн төслийн 3.1.3-т “бүхэл цус” гэж уламжлалт аргаар авч байгаа цусыг хэлнэ гэж тодорхойлсон боловч уламжлалт арга гэдэг нь тодорхойгүй, 5.2.1-д “эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас цус сэлбэлт судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрх олгох зөвшөөрлийн хяналт” гэж заасан зэрэг нь ойлгомжгүй байна. | | судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хяналт; |

# ЦУСНЫ ДОНОРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН

2025 он

## АГУУЛГА

1. Нийтлэг зүйл
2. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлт
3. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсэг
4. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгсэлийн дагуу үнэлсэн хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ
5. Үр дүн, зөвлөмж

## Нэг. Нийтлэг зүйл

Цусны донорын тухай хуулийн төсөлд шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийн, түүний үр нөлөөг тооцож, хуулийн төслийг боловсронгуй болгоход энэхүү үнэлгээний ажлын зорилго оршино.

Цусны донорын тухай хуулийн төсөл /Цаашид "Хуулийн төсөл" гэх/-ийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал" /Цаашид "Аргачлал" гэх/ -ын 1-д заасны дагуу:

- Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх гэсэн үе шатыг баримтлан гүйцэтгэлээ.

## Хоёр. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал, үндэслэл

Тус үнэлгээний ажлыг гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтийг сонголоо.

1.Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал;
4. Ойлгомжтой байдал;
5. Зардал;
6. Харилцан уялдаа зэрэг болно.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

**Зорилгод хүрэх байдал:**

Хуулийн төсөл нь цусны донорын үйл ажиллагаа, түүнд оролцогчдын нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож байгаа анхдагч хуулийн төсөл юм.

Хуулийн төсөл нь "Цус сэлбэлт судлалын үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомж, баримтлах зарчим, түүнд тавих төрийн хяналт, цус сэлбэлт судлалын харилцаанд хамаарах этгээд, түүний удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн үндэс, санхүүжилт, эрх, үүрэг, цусны донор, сэлбүүлэгч, тэдэнд тавигдах шаардлага, эрх үүрэг, эрүүл мэндийн үзлэгт хамрагдах, цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ үнэ төлбөргүй өгөх, түүнийг шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, өвчтөнд сэлбэхтэй холбоотой харилцаа, цус, цусан бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа болон уг үйл ажиллагаатай холбоотой үүсэх төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэний эрх, үүргийг тодорхойлохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулах" зорилгодоо хүрсэн эсэхийг хянан үзнэ.

**Практикт хэрэгжих боломж:**

Хуулийн төсөлд тусгагдсан асуудлууд болох 1/цусны донорын харилцааг бодлогын хэмжээнд зохицуулах, хянах тогтолцоо, 2/цусны донорын үйл

ажиллагааны санхүүжилтийн тогтолцоо, 3/цусны донор, сэлбүүлэгч, эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэгтэй холбоотой тогтолцоо, 4/донороос цус, түүний бүрэлдэхүүн хэсэг цуглуулах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, сэлбэх, устгах тогтолцоо, 5/цусны донорын эгнээг өргөжүүлэх тогтолцоо, 6/гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үе дэх цусны донорын үйл ажиллагааны тогтолцоо, 6/цусны донорын мэдээллийн сангийн тогтолцоог бий болгох, сайжруулах боломж, бололцоо байгаа эсэхийг нягтлана.

**Хүлээн зөвшөөрөгдсөн байдал:**

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн болон орон нутаг дахь Цусны салбар төвийн ажилтнуудаас авсан судалгаагаар Цус сэлбэлт судлалын үндэсний төв тусгай мэргэжлийн төвийн хувьд улсын төсвөөс санхүүжиж байхад Цусны салбар төвүүд орон нутгийн нэгдсэн эмнэлэгт харьяалагдаж Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих болсноор Цусны салбар төвийн эмнэлгийн мэргэжилтнүүдэд орон тоо, цалин, хөлстэй холбоотой хүндрэл үүсэх, хүний нөөцийн тогтвортой байдал алдагдах, зарим Цусны салбар төвийн өрөө, тасалгааг өөр зорилгоор ашиглахаар шилжүүлсэн байгаа нь зөвхөн цус сэлбэлт судлалын салбарт ч биш эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйл болж болзошгүй байгаа юм. Иймээс цус сэлбэлт судлалын салбарт ажилладаг эрүүл мэндийн ажилтнуудыг урамшуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх, тэдний нийгмийн асуудлыг дэмжих асуудал тулгамдаж байна.

Цусны доноруудаас авсан судалгаагаар цусны байнгын донорт дэмжлэг үзүүлэх, тэдний эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, халамжийн асуудлыг сайжруулах, цус өгсөн донорыг илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүнээр үйлчлэх, хүн амын дунд ялангуяа оюутан, сурагчдад цусны донорын нийгмийн ач холбогдлыг таниулсан сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх, цусны донорын үйл ажиллагааг дэмжин хамтран ажилласан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулах, цусны донорын үйл ажиллагааг дэмжин зарцуулсан зардлыг нь татвараас чөлөөлөх зэрэг цусны нөөц хангамжийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчин бий болгох, үндэсний аюулгүй байдалтай холбоотой онцлог салбарын хувьд төрөөс цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн талаар онцгойлон анхаарах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

**Ойлгомжтой байдал:**

Хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томьёологдёон эсэхийг шалгах үүднээс хамаарах этгээдүүдээс санал авах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль, тогтоомжийг боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

**Зардал:**

Хуулийн төслөөр хэрэгүүүлэгч этгээдэд төсвийн ачаалал үүсэх эсэх, хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал гарах эсэхийг тооцон судлах байдлаар сонгов.

**Харилцан уялдаа:**

Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомж болон төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субьектуудын чиг үүрэг давхардал, зөрчилдөөнгүй бичигдсэн.

Хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын Үндсэн хууль, Засгийн газрын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль зэрэг холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

**Гурав.Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон байдал**

Энэ хэсэгт хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Сонгохдоо хууль зүйн шууд үр дагавар үүсэж буй хууль зүйн ач холбогдол бүхий заалтыг сонгоно. Түүнчлэн төсөл батлагдсанаар тодорхой этгээдэд шинээр үүрэг хүлээлгэсэн эсэх, шинээр нэгж, байгууллага бий болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөөг тооцох хэсгээ сонгосон.

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо:

Хүснэгт-1

| Д/д | Шалгуур үзүүлэлт | Үр нөлөөг үнэлэх хэсэг | Тохирох шалгах хэрэгсэл |
|---|---|---|---|
| 1 | Зорилгод хүрэх байдал | Хуулийн төслийн холбогдох зохицуулалт | Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх. |
| 2 | Практикт хэрэглэх боломж | Хуулийн төслийн холбогдох зохицуулалт | Цусны донорын харилцааг зохицуулж ирсэн зохицуулалт, сайн туршлага, нэгдсэн тогтолцоонд шилжих асуудлыг хуульчлах боломж, давуу, сул тал, цусны донорын харилцааг зохицуулах нэгдсэн тогтолцоо, цусны донор, сэлбүүлэгч, эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг, цусны донорын сургалт, сурталчилгаа, элсүүлэлт, алдаршуулалт, урамшуулал, нийгмийн халамж, дэмжлэг, эмнэлгийн мэргэжилтний цалин, хөлсийг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг хангах зэрэг чиглэлээр судалж, цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан тусгай мэргэжлийн төвийн статистик мэдээ, цус, цусан бүтээгдэхүүний үнэ батлагдсантай холбоотой төсвийн орлого, зарлагын байдал, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх. |
| 3 | Ойлгомжтой байдал | Хуулийн төслийн зохицуулалтыг | Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль |

| | | | |
|---|---|---|---|
| | | бүхэлд нь хамруулах | тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах. |
| 4 | Хүлээн зөвшөөрөгдөх байдал | Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах | Хуулийн төслийг хүлээн зөвшөөрөх байдлыг судалгаа хийж, цусны донор, эмнэлгийн мэргэжилтнүүд болон бусад харилцаанд оролцогчид хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгах. |
| 5 | Зардал | Хуулийн төслийн холбогдох зохицуулалт | Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан болон Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу зардлын тооцоо хийж, улсын төсөвг аж ахуйн нэгжид санхүүгийн дарамт учруулах эсэхийг шалгах. |
| 6 | Харилцан уялдаа | Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах | Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.15, 29.17, 29.1.10-т болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг шалгах. |

### 3.1.Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

Хуулийн төслийн зорилго нь “Цус сэлбэлт судлалын үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомж, баримтлах зарчим, түүнд тавих төрийн хяналт, цус сэлбэлт судлалын харилцаанд хамаарах этгээд, түүний удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн үндэс, санхүүжилт, эрх, үүрэг, цусны донор, сэлбүүлэгч, тэдэнд тавигдах шаардлага, эрх үүрэг, эрүүл мэндийн үзлэгт хамрагдах, цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ үнэ төлбөргүй өгөх, түүнийг шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, өвчтөнд сэлбэхтэй холбоотой харилцаа, цус, цусан бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа болон уг үйл ажиллагаатай холбоотой үүсэх төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэний эрх, үүргийг тодорхойлохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан.

Энэ зорилгын хүрээнд хуулийн зорилтыг “Цусны донорын үйл ажиллагаатай холбоотой төрийн бодлого, зохицуулалт, баримтлах зарчим, түүнийг хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн үндэс, санхүүжилтийн тогтолцоо, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэний эрх, үүрэг, цус сэлбэлт

судлалын албанд ажиллагсадын цалин, хөлс, нийгмийн баталгаатай холбогдсон харилцааг зохицуулах.” гэж тодорхойлсноор зорилгод хүрэхтэй холбоотой хуулиар зайлшгүй зохицуулах шаардлагатай асуудлыг тусгасан.

Цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, нөөц хангамжийн тогтвортой байдлыг хангах, цусны донорын үйл ажиллагааг удирдан зохицуулахтай холбоотой төрийн зохицуулалт, харилцаанд оролцогч байгууллагуудын эрх зүйн байдлыг хуулийн төслийн Хоёрдугаар бүлгийн 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15 дугаар зүйлд, цусны донор, сэлбүүлэгч, эрүүл мэндийн ажилтанд тавигдах шаардлага, эрх үүргийг хуулийн төслийн Гуравдугаар бүлгийн 16, 17, 18, 19, 20, 21 дүгээр зүйлд, цусны донорын эгнээг өргөжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа, цусны донорыг алдаршуулах, урамшуулах, тэдэнд үзүүлэх нийгмийн халамж, дэмжлэгийг хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлгийн 22, 23, 24 дүгээр зүйлд, цус цуглуулах, цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, шинжлэх, хадгалах, тээвэрлэх, сэлбэхтэй холбоотой харилцааг хуулийн төслийн Тавдугаар бүлгийн 25, 26, 27 дугаар зүйлд, гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үе дэх цусны донорын үйл ажиллагааг хуулийн төслийн Зургаадугаар бүлгийн 28 дугаар зүйлд, цусны донорын мэдээллийн сантай холбоотой харилцааг хуулийн төслийн Долоодугаар бүлгийн 29, 30 дугаар зүйлд, хариуцлагын асуудлыг Наймдугаар бүлгийн 31, 32, 33 дугаар зүйлд тус тус тодорхойлсноор зорилгод хүрэхэд шаардлагатай арга хэмжээг иж бүрэн авч үзсэн байна гэж үзэж байна.

| Зорилгод хүрэх байдал | Сонгосон зүйл, заалт |
|---|---|
| Монгол Улсын “Донорын тухай” хууль анх 2000 онд батлагдаж, 2012, 2015, 2021 онд тус тус нэмэлт, өөрчлөлт орж, 2018 онд шинэчлэн найруулсан. Тус хуулиар бусдын эрүүл мэндийг сайжруулах, амь насыг аврахын тулд хүмүүнлэг сэтгэлээр сайн дураараа цус, эд, эрхтнээ үнэ төлбөргүй өгөх, амьд болон амьгүй донорын эд, эрхтэнг шилжүүлэн суулгах эмчилгээний зорилгоор хэрэглэхээр авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, донорын үйлсийг сурталчлах, түүнд иргэдийг татан оролцуулахтай холбогдсон харилцааг зохицуулж байна.<br>Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) “Цусны аюулгүй байдлын Санамж бичиг – 8 (2002-2018), Дэлхийн эрүүл мэндийн ассамблейн чуулганы WHA 28.72 (1975), 58.13 (2005), 63.12 (2010) тогтоолыг тус тус баталсан. ДЭМБ-ын Улс үндэстнүүдийн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад зориулсан Санамж бичиг, Үндэсний хэмжээний эрүүл мэндийн бодлого боловсруулагчдад зориулсан Санамж бичиг, Цусны талаарх үндэсний хөтөлбөрийг боловсруулахад анхаарах Санамж бичигт Үндэсний хэмжээний зохицуулгатай, сайтар зохион байгуулагдсан, бүх шатанд үр дүнтэй ажилладаг цусны албыг байгуулах, цус, цусан бүтээгдэхүүний хүрэлцээ, хангамж, аюулгүй байдлыг үнэлэх, цусны албыг хөгжүүлэх зэрэг | |

бодлогын чанартай шийдвэр гаргах үүрэг бүхий үндэсний удирдах байгууллагыг байгуулах, сайн дурын авлагагүй донoруудаас цус цуглуулж байх, цусыг эмчилгээнд зохистой хэрэглэхийг зөвлөмж болгосон.

““Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 2.2.10-д “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.”, 2.2.11-т “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна.”, 2.2.15-д “Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний үеийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор олон улсын жишигт нийцсэн төвийг төрөлжүүлэн байгуулна” (Зүрх судасны төв, Эрхтэн шилжүүлэн суулгах төв, Яаралтай тусламжийн үндэсний төв гэх мэт) гэж тус тус заасантай уялдуулан Цус сэлбэлт судлалын салбарын зохион байгуулалт, бүтцийг боловсронгуй болгох, цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг онцгой анхаарч, нөөц, хангамжийн тасралтгүй байдлыг хангах шаардлага тулгарч байна.

**Хуулийн зорилго:** Цус сэлбэлт судлалын үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомж, баримтлах зарчим, түүнд тавих төрийн хяналт, цус сэлбэлт судлалын харилцаанд хамаарах этгээд, түүний удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн үндэс, санхүүжилт, эрх, үүрэг, цусны донор, сэлбүүлэгч, тэдэнд тавигдах шаардлага, эрх үүрэг, эрүүл мэндийн үзлэгт хамрагдах, цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ үнэ төлбөргүй өгөх, түүнийг шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, өвчтөнд сэлбэхтэй холбоотой харилцаа, цус, цусан бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа болон уг үйл ажиллагаатай холбоотой үүсэх төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэний эрх, үүргийг тодорхойлохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

**Хуулийн зорилт:** Цусны донорын үйл ажиллагаатай холбоотой төрийн бодлого, зохицуулалт, баримтлах зарчим, түүнийг хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн үндэс, санхүүжилтийн тогтолцоо, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэний эрх, үүрэг, цус сэлбэлт судлалын албанд ажиллагсадын цалин,

| | |
|---|---|
| хөлс, нийгмийн баталгаатай холбогдсон харилцааг зохицуулах. | |

**3.2.Практикт хэрэглэх боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал**

| Практикт хэрэглэх боломж | Сонгосон зүйл, заалт |
|---|---|
| “Донорын тухай” хууль анх 2000 онд батлагдаж, 2012, 2015, 2018, 2021 онд тус тус нэмэлт, өөрчлөлт орсон. Тус хуулиар бусдын эрүүл мэндийг сайжруулах, амь насыг аврахын тулд хүмүүнлэг сэтгэлээр сайн дураараа цус, эд, эрхтэнээ үнэ төлбөргүй өгөх, амьд болон амьгүй донорын эд, эрхтэнг шилжүүлэн суулгах эмчилгээний зорилгоор хэрэглэхээр авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах, донорын үйлсийг сурталчлах, түүнд иргэдийг татан оролцуулахтай холбогдсон харилцааг зохицуулж байна.<br>Цусны донорын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах болсон шалтгаан нь сүүлийн жилүүдэд хүн ам өсөн нэмэгдэх, анагаах ухааны салбарт эрхтэн шилжүүлэн суулгах зэрэг эмчилгээ, үйлчилгээ Монгол Улсад шинээр нэвтрэхийн хэрээр иргэдийн дунд цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх хэрэгцээ жил бүр өсөн нэмэгдэж байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд өвчлөл болон нас баралтын тэргүүлэх шалтгаанд зүрх судасны өвчлөл, элэг, бөөрний эмгэг, хорт хавдар, осол гэмтэл орж байна.<br>Хуулийн төсөлд цусны донорын үйл ажиллагаан дахь төрийн хяналт, Засгийн газрын бүрэн эрх, цус сэлбэлт судлалын харилцаанд оролцох байгууллага, түүний удирдлагын болон санхүүжилтийн тогтолцоог тодорхойлох, цусны донор, сэлбүүлэгч, цус сэлбэлт судлалын үйл ажиллагаанд оролцогч эмнэлгийн мэргэжилтэнд тавих шаардлага, тэдний эрх үүргийг тодорхойлох, донороос цус, түүний бүрэлдэхүүн хэсэг авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, сэлбэх, устгах үйл ажиллагааг нарийвчлан зохицуулах, гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн болон цусны донорын мэдээллийн сангийн харилцааг шинээр бий болгох, цусны донорын эгнээг өргөжүүлэх үйл ажиллагаанд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах, цусны донорын үйлсийг сурталчлах, элсүүлэхэд санхүү, эд материалын дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгж байгууллагад зарцуулсан хөрөнгийн хэмжээгээр аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх дэмжлэг үзүүлэх замаар сургалт, сурталчилгаа, элсүүлэлтийг шинэ түвшинд | |

| | |
|---|---|
| гаргах, цус сэлбэлт судлалын салбарт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтнуудын цалин, хөлс, нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.<br>Эдгээр өөрчлөлтүүдийг хуульчлан үйл ажиллагаанд хэрэгжүүлж чадсанаар цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, нөөц хангамжийн тасралтгүй байдал дээшилж олон хүний амь нас эрүүл мэндийг аврах боломж нэмэгдэн, улсын төсөвт ирэх ачаалал буурна. Мөн эх орондоо биобэлдмэл үйлдвэрлэх төрийн бодлого, шийдвэрийг бодитойгоор хэрэгжих нөхцөл бүрдэнэ.<br>Цусны донорын тухай хуулийн төслийн саналыг ЭМЯ-ны хэмжээнд энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг эмч, мэргэжилтэн, эрдэмтэн багш, профессоруудаас бүрдсэн томоохон ажлын хэсэг байгуулагдан 3 дэд хэсэгт орж чиглэл тус бүрээр хуулийн төслийг боловсруулан ажилласан болно. | |

Цусны донорын үйл ажиллагааны тогтолцоо нь төрийн зохицуулалт, хяналт, Монгол Улсын Засгийн газар, харилцаанд оролцогч бусад байгууллагаас, удирдлагын тогтолцоо нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага, цусны төв, бусад эрүүл мэндийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга, бусад байгууллагаас тогтохоор заасан.

Цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, нөөц, хангамжийн тогтвортой байдлыг хангахад төрийн зохицуулалт, хяналт чухал үүрэгтэй бол цусны донорын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хуулийн төсөлд заасан субьектуудын оролцоо зайлшгүй байх ёстой байдаг. Түүнчлэн цусны донорын үйл ажиллагаан дахь санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгох замаар цусны донорын сургалт, сурталчилгааг хэрэгжүүлэх, тэднийг алдаршуулах, урамшуулах, нийгмийн халамж, дэмжлэг үзүүлэх, цус сэлбэлт судлалын салбарт ажиллагсдыг мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх нь тулгамдсан асуудлын нэг болсон тул төрийн зохицуулалт, хяналт, Монгол Улсын Засгийн газрын болон бусад байгууллагын эрх хэмжээ, санхүүжилтийн тогтолцоог тусгасан байна.

### 3.3.Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд Цусны донорын тухай хуулийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 26, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ. Мөн хуулийн төсөлд холбогдох эмнэлгийн мэргэжилтэн, цусны донорууд, байгууллагуудаас ойлгломжтой болгох чиглэлээр ирүүлсэн санал байгаа эсэхийг нягтлан, дүн шинжилгээ хийсэн болно.

Хуулийн төсөлд сонирхогч талуудаас санал авах ажлыг зохион байгуулж, ирүүлсэн саналыг судлан үзэхэд цусны донорын эрх, нийгмийн халамж, дэмжлэг,

тэдэнд өгөх илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүнийг сайжруулах, санхжүүжилтийн тогтолцоог сайжруулах замаар цус сэлбэлт судлалын салбарын ажиллагсадын цалин, хангамж, нийгмийн асуудлыг дээшлүүлэх, нэгдмэл тогтолцоонд шилжих замаар цусны аюулгүй байдлыг сайжруулах асуудал голчлон ирж байлаа.

Хуулийн төсөл 8 бүлэг, 33 зүйлтэй бөгөөд хуулийн бүлэг, зүйл, хэсэг, заалтын хоорондын уялдаа хангагдсан, ойлгомжтой байна.

### 3.4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгээ тогтоосон байдал

Тус шалгуурын хүрээнд хуулийн төслийн зохицуулалтуудыг харилцаанд оролцогч субьектууд хэрхэн хүлээн зөвшөөрөх, цусны донор, сэлбүүлэгч, эмнэлгийн мэргэжилтний эрх, хууль ёсны ашиг сонирхол хангагдсан эсэх, шинээр бий болгосон үүрэг хэрэгжих боломжтой эсэхийг хянан үзнэ.

“Донорын тухай хууль” 2018 онд шинэчлэн батлагдаж түүнийг хэрэгжүүлэх, дагаж мөрдөх журмуудын хэрэгжилтийг хангах явцад гарч байсан санал, дүгнэлт, бодит амьдрал, үйл ажиллагааны явцад тохиолдсон асуудал, хүндрэлтэй байдлуудыг шийдэх талаар хуулийн төсөлд шинээр боловсруулан мэргэжилтнүүдийн санаа оноо, бодол оюун ухааныг тусгасан. Донорын тухай хууль маань тухайн үеийн хэрэгцээ шаардлагыг зохицуулж байсан боловч цагийн аясаар Цусны донорын тухай бие даасан хууль байх хэрэгтэй болсон нь амьдрал практик үйл ажиллагааны явц харуулж байна. Иймд энэхүү хуулийн төсөл нь мэргэжлийн зүгээс хүлээн зөвшөөрөгдсөн, практик үйл ажиллагаанд илүү нийцсэн баримт бичиг болно.

Хуулийн төсөлд цус сэлбэлт судлалын тогтолцоо, түүнд тавих төрийн хяналт, цусны донорын үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын эрх, хэмжээг тодорхойлж, цусны донор, сэлбүүлэгч, цус сэлбэлт судлалын салбарын эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг, цус сэлбэлт судлалын асуудал эрхэлсэн тусгай мэргэжлийн төв, цусны төв түүний санхүүжилт, бусад байгууллагатай харилцах уялдааг тодорхойлох, гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед цусны донорын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, цусны донорын сургалт, сурталчилгаа, алдаршуулалт, урамшуулал, тэдэнд үзүүлэх нийгмийн халамж, дэмжлэг, цус сэлбэлт судлалын салбарт ажиллагчдын цалин, нийгмийн баталгааг сайжруулах, шинээр бүрдүүлэх, цусны донорын үйл ажиллагааг дэмжигч аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх хөнгөлөлтөөр дамжуулан харилцаанд оролцогчдын эрх, ашиг сонирхолыг хамгаалахад чиглэсэн зохицуулалт болжээ.

### 3.5.Зардал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинэ орон тоо, зардал гарахгүй бөгөөд орон нутгийн эмнэлэгт харьяалагдаж байгаа Цусны төвийг нэгдсэн зохион байгуулалтад шат дараалан шилжүүлэхтэй холбоотойгоор орон тоо, тоног төхөөрөмж, байр ашиглалтын болон цусаар дамжих халдвар илрүүлэх шинжилгээний зарим зардал шилжинэ. Мөн цус, салбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын өөрийн орлогоор эргэлтийн сан бүрдүүлж, шинээр бий болон цусны албаны нэмэгдэл цалин, нийгмийн асуудлыг шийдвэрлэх,

улсын төсөвт хангалттай тусгагддаггүй бусад зардлыг санхүүжүүлэх замаар цус сэлбэлт судлалын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах, цусны донор өгөх илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, чанарыг сайжруулах, цусны донорын сургалт, сурталчилгаа, алдаршуулалт, урамшууллыг шинэ шатанд гаргахаар зохицуулсан бөгөөд улсын төсөвт нэмэлт дарамт үүсгэхгүй.

Аж ахуйн нэгж байгууллагуудаас цусны донорын үйл ажиллагаанд зарцуулах зардлыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлснөөр цусны донорт хандах хандлага сайжрах, тэднийг алдаршуулах, урамшуулахад ихээхэн дэмжлэг болох бөгөөд зардлын үнэлгээгээр улсын болон орон нутгийн төсөвт дутагдал үүсгэхгүй.

**3.6. Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ**

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзлээ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэллээ:
Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:

| Д/д | Шалгах асуулт | Шаардлагыг хангасан эсэх |
|---|---|---|
| 1 | 29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх | Үндсэн хуульд заасан зарчмыг хангахад чиглэсэн бөгөөд ямар нэгэн байдлаар зөрчилдөөгүй байна. |
| 2 | 29.1.5. зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх | Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зарчмын томоохон зөрчил байхгүй байна. Харин зарим нэг тодруулах, уялдааг хангах, сайжруулах шаардлагатай асуудлыг үнэлгээний Зөвлөмж хэсэгт тусгасан болно. |
| 3 | 29.1.7. бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэг болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх | **Энэхүү хуулийн төсөлд зүйл, заалт хооронд эшлэл хэрэглэсэн байна. Иймд хуулийн төслийн зохицуулалтын өөрчлөлт, засварыг харгалзан, эшлэлийг нягтлах нь зүйтэй байна.** |
| 4 | 29.1.10. шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай | Тус хуулийн төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах ... хуулийн төсөл, ... УИХ-ын тогтоолын төсөл 1, Засгийн газрын тогтоолын төсөл 2-ыг тус тус |

| | | |
|---|---|---|
| | дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх | боловсруулсан байна. |

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан уялдаа холбоог шалгах хэрэгсэлд дурдагдсан шалгуурыг хангах эсэх:

| Д/д | Асуулт | Хариулт | Дүн шинжилгээ |
|---|---|---|---|
| 1 | Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх | Тийм | Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна. |
| 2 | Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр харилцаанд хамаарах хууль мөн эсэх | Тийм | Энэхүү шаардлагыг хангасан байна. |
| 3 | Хуулийн төсөлд тодорхойлсон нэг томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх | Тийм | Хуулийн төслийн 3 дугаар зүйлд нэр томьёог Тайлбар хэлбэрээр туссан байна. Мөн хуулийн төслийн хэлэлцүүлэг болон төсөлд ирүүлсэн саналаас үзэхэд “..........”, “..... ” зэрэг нэр томьёог найруулга, бичвэрийн томьёоллын хувьд ойлгомжтой болгох шаардлагатай |
| 4 | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх | Тийм | Дүн шинжилгээний хүрээнд зарчмын зөрүүтэй ямар нэгэн асуудал илрээгүй бөгөөд тодруулах, нэмэлт хийх шаардлагатай зохицуулалт байна. |
| 5 | Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх | Тийм | Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.1 дэх хэсэгтэй нийцэж байгаа эсэхийн нягтлах, |
| 6 | Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх | Тийм | Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна. |
| 7 | Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх | Тийм | Хуулийн төслийг зохицуулалтыг тодруулах, хэрэгжих боломжийг |

| | | | |
|---|---|---|---|
| | | | нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байна. |
| 8 | Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх | Үгүй | Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй. |
| 9 | Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх | - | Энэхүү зохицуулалтыг нарийвчлан тодорхой зарчмыг тогтоосон байна. |
| 1<br>0 | Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх | Тийм | Төсөлд ямар нэг хураамж тусгагдаагүй. |
| 1<br>2 | Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх | Тийм | Хуулийн төсөлд тусгасан хязгаарлалт нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, хуульд заасан зайлшгүй бөгөөд хүний хууль ёсны ашиг сонирхлыг хуулиас гадуур хөндөхгүй байх нөхцөлийг тусгасан байна. |
| 1<br>3 | Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх | - | Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой. |
| 1<br>4 | Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх | Үгүй | Хуулийн төслийн тусгагдаагүй болно. |
| 1<br>5 | Хуулийн төсөлд авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх | Үгүй | Хяналтаар энэ төрлийн зөрчил илрээгүй. |
| 1<br>6 | Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой | - | Тухайн хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Төрийн албаны |

| | | | |
|---|---|---|---|
| | тусгасан эсэх. | | тухай хууль болон энэ хуулиар зохицуулсан байх тул нэмэлтээр оруулах шаардлагагүй байна. |

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл, заалт нь Үндсэн хууль, олон улсын гэрээ, бусад хуультай нийцсэн, хуулийн дотоод зөрчил илрээгүй ба байгууллага, албан тушаалтны чиг үүрэгт давхардал үүсээгүй байна.

## Дөрөв. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

### 4.1. Үнэлэлт, дүгнэлт

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт бүрээр дараах байдлаар үнэлж, дүгнэлээ.

**Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр:**

Цусны донорын тухай хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн, холбогдох зохицуулалтыг тусгасан байна. Зохицуулалтыг илүү нарийвчлах, хэрэгжих боломжийг нь нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

**Практикт хэрэглэх боломж шалгуур үзүүлэлтээр:**

“Донорын тухай” хууль анх 2000 онд батлагдаж, 2012, 2015, 2018, 2021 онд тус тус нэмэлт, өөрчлөлт орсон. Тус хуулиар бусдын эрүүл мэндийг сайжруулах, амь насыг аврахын тулд хүмүүнлэг сэтгэлээр сайн дураараа цус, эд, эрхтэнээ үнэ төлбөргүй өгөх, амьд болон амьгүй донорын эд, эрхтэнг шилжүүлэн суулгах эмчилгээний зорилгоор хэрэглэхээр авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах, донорын үйлсийг сурталчлах, түүнд иргэдийг татан оролцуулахтай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Цусны донорын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах болсон шалтгаан нь сүүлийн жилүүдэд хүн ам өсөн нэмэгдэх, анагаах ухааны салбарт эрхтэн шилжүүлэн суулгах зэрэг эмчилгээ, үйлчилгээ Монгол Улсад шинээр нэвтрэхийн хэрээр иргэдийн дунд цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх хэрэгцээ жил бүр өсөн нэмэгдэж байна.

Хуулийн төсөлд цусны донорын үйл ажиллагаан дахь төрийн хяналт, Засгийн газрын бүрэн эрх, цус сэлбэлт судлалын харилцаанд оролцох байгууллага, түүний удирдлагын болон санхүүжилтийн тогтолцоог тодорхойлох, цусны донор, сэлбүүлэгч, цус сэлбэлт судлалын үйл ажиллагаанд оролцогч эмнэлгийн мэргэжилтэнд тавих шаардлага, тэдний эрх үүргийг тодорхойлох, донороос цус, түүний бүрэлдэхүүн хэсэг авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, сэлбэх, устгах үйл ажиллагааг нарийвчлан зохицуулах, гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн болон цусны донорын мэдээллийн сангийн харилцааг шинээр бий болгох, цусны донорын эгнээг өргөжүүлэх үйл ажиллагаанд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах, цусны донорын үйлсийг сурталчлах, элсүүлэхэд санхүү, эд материалын дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгж байгууллагад зарцуулсан хөрөнгийн хэмжээгээр аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх дэмжлэг үзүүлэх замаар сургалт, сурталчилгаа, элсүүлэлтийг шинэ түвшинд

гаргах, цус сэлбэлт судлалын салбарт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтнуудын цалин, хөлс, нийгмийн асуудлыг шийдвэрлэх юм.

Эдгээр өөрчлөлтүүдийг хуульчлан үйл ажиллагаанд хэрэгжүүлж чадсанаар цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдла, нөөц хангамжийн тасралтгүй байдал дээшилж олон хүний амь нас эрүүл мэндийг аврах боломж нэмэгдэн, улсын төсөвт ирэх ачаалал буурна. Мөн эх орондоо биобэлдмэл үйлдвэрлэх төрийн бодлого, шийдвэрийг бодитойгоор хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

**Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр:**

Донорын тухай хууль батлагдаад 4 жил 5 сарын хугацаа өнгөрч байна. Донорын тухай хууль нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 26, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан хэлбэрээр боловсруулагдаж байсан бөгөөд Цусны донорын тухай хуулийн төслийг Донорын тухай хуульд байсан эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах хэсгийг авч өнөөгийн нөхцөл шаардлагад нийцүүлэн өөрчилсөн бөгөөд харин цоо шинээр орж ирж буй эс, эд, үр шилжүүлэн суулгах талын зохицуулалтуудыг ойлгомжтой байдлаар боловсруулан оруулсан.

**Хүлээн зөвшөөрөгдсөн байдал шалгуур үзүүлэлтээр:**

"Донорын тухай хууль" 2018 онд шинэчлэн батлагдаж түүнийг хэрэгжүүлэх, дагаж мөрдөх журмуудын хэрэгжилтийг хангах явцад гарч байсан санал, дүгнэлт, бодит амьдрал, үйл ажиллагааны явцад тохиолдсон асуудал, хүндрэлтэй байдлуудыг шийдэх зорилгоор энэхүү нэмэлт өөрчлөлтүүдийг оруулан одоо 2022 оны УИХ-ын Хаврын ээлжит чуулганаар хэлэлцэгдэн батлагдсан бөгөөд энэхүү хуулиас Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний тухай хуулийн төслийг биеэ даасан хууль болгон боловсруулсан болно. Энэхүү хуулийн төсөл нь ЭМЯ-аас томилон байгуулсан ажлын хэсгээс мэргэжил тус бүрийн ажлын дэд хэсгээр хэлэлцэгдэн боловсруулагдаж зохих мэргэжлийн зөвлөл, хуулийн зөвөлгөө, олон нийтийн санал бодлыг тусгасан болно. Иймд хуулийн төсөл нь нь мэргэжлийн зүгээс хүлээн зөвшөөрөгдсөн, практик үйл ажиллагаанд илүү нийцсэн баримт бичиг болно.

**Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр:**

- Хуулийн зүйл, заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтны чиг үүрэгт давхардал үүсээгүй байна.

Энэхүү үр нөлөө тооцох үнэлгээг цус сэлбэлт судлалын чиглэлээр ажиллагдах эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн мэргэжилтнүүд, цусны доноруудаас ирүүлсэн саналуудыг үндэслэн хийлээ.

Цусны донорын тухай хууль нь дэвшүүлсэн зорилгоо хангах эсэх, практикт хэрхэн хэрэгжих эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараахь **Дүгнэлт**ийг хийж, **Зөвлөмж** боловсрууллаа.

**4.2. Зөвлөмж**

Энэхүү үр нөлөөг тооцох үнэлгээг Цусны донорын тухай хуулийн үзэл баримтлалын хүрээнд хийлээ.

Үнэлгээнд хуулийн үзэл баримтлалаас гадна эрх бүхий байгууллагуудаас энэхүү хуулийн хүрээнд зохицуулах харилцаатай холбогдуулан батлан гаргасан

журам, заавар, стандарт, стандарт тоон үзүүлэлтүүд, тайлан мэдээлэл, холбогдох хууль тогтоомж, тэдгээрийн албан ёсны болон албан бус тайлбарууд зэрэг олон нэмэлт материалыг ашигласан болно. Харин хуулийн зохицуулалтыг тодруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

-- O --

# ЦУСНЫ ДОНОРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 он

# АГУУЛГА

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан, нөхцөл

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫГ ТОГТООЖ, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

4.1. Хүний эрхэд үзүүлэх нөлөө

4.2. Эдийн засагт үзүүлэх нөлөө

4.3. Нийгэмд үзүүлэх нөлөө

4.4. Байгаль орчинд үзүүлэх нөлөө

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

**Судалгааны аргачлал:**

Энэхүү судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоолын 01 дүгээр хавсралтад заасан "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судлах аргачлал"-ын дагуу хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Асуудалд дүн шинжилгээ хийх;
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томьёолох;
3. Тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
4. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;
5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх;
6. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх;
7. Зөвлөмж боловсруулах.

# НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Монгол Улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болох[1] алсын хараатайгаар Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор "Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ыг баталсан. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай" тогтоолд тусгагдсан "Цусны донорын тухай" хуулийн төсөл боловсруулах зорилтын хүрээнд "Хууль тогтоомжийн тухай" хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"-ын дагуу Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/132 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгээс цусны донор, цус сэлбэлт судлалын хөгжлийн асуудалд дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудал, түүний хууль, эрх зүйн орчныг судлах, хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагатай эсэхийг тодруулахыг зорилоо.

## 1.1 Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

Аргачлалын 3-т заасны дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд, асуудлыг үүсгэж байгаа шалтгаан нөхцлийг тодорхойлсон болно.

Монгол Улсын "Донорын тухай" хууль анх 2000 онд батлагдаж, 2012, 2015, 2021 онд тус тус нэмэлт, өөрчлөлт орж, 2018 онд шинэчлэн найруулсан. Тус хуулиар бусдын эрүүл мэндийг сайжруулах, амь насыг аврахын тулд хүмүүнлэг сэтгэлээр сайн дураараа цус, эд, эрхтнээ үнэ төлбөргүй өгөх, амьд болон амьгүй донорын эд, эрхтэнг шилжүүлэн суулгах эмчилгээний зорилгоор хэрэглэхээр авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, донорын үйлсийг сурталчлах, түүнд иргэдийг татан оролцуулахтай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) "Цусны аюулгүй байдлын Санамж бичиг – 8 (2002-2018), Дэлхийн эрүүл мэндийн ассамблейн чуулганы WHA 28.72 (1975), 58.13 (2005), 63.12 (2010) тогтоолыг тус тус баталсан. ДЭМБ-ын Улс үндэстнүүдийн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад зориулсан Санамж бичиг, Үндэсний хэмжээний эрүүл мэндийн бодлого боловсруулагчдад зориулсан Санамж бичиг, Цусны талаарх үндэсний хөтөлбөрийг боловсруулахад анхаарах Санамж бичигт Үндэсний хэмжээний зохицуулгатай, сайтар зохион байгуулагдсан, бүх шатанд үр дүнтэй ажилладаг цусны албыг байгуулах, цус, цусан бүтээгдэхүүний хүрэлцээ, хангамж, аюулгүй байдлыг үнэлэх, цусны албыг хөгжүүлэх зэрэг бодлогын чанартай шийдвэр гаргах үүрэг бүхий үндэсний удирдах байгууллагыг байгуулах, сайн дурын авлагагүй доноруудаас цус цуглуулж байх, цусыг эмчилгээнд зохистой хэрэглэхийг зөвлөмж болгосон.

""Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны 2.2.10-д "Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын

[1] Алсын хараа 2050 Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлого, 27 дугаар тал.

нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.", 2.2.11-т "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна.", 2.2.15-д "Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний үеийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор олон улсын жишигт нийцсэн төвийг төрөлжүүлэн байгуулна" (Зүрх судасны төв, Эрхтэн шилжүүлэн суулгах төв, Яаралтай тусламжийн үндэсний төв гэх мэт) гэж тус тус заасантай уялдуулан Цус сэлбэлт судлалын салбарын зохион байгуулалт, бүтцийг боловсронгуй болгох, цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг онцгой анхаарч, нөөц, хангамжийн тасралтгүй байдлыг хангах шаардлага тулгарч байна.

Монгол Улсын Их Хурлаас 2007 онд "Монгол Улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлого" баталсан бөгөөд уг бодлогын хэрэгжилтийг хангах төлөвлөгөө (2008-2015 он)-г Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 111 дүгээр тогтоолоор батлан, 5 зорилтын хүрээнд 41 арга хэмжээ төлөвлөн 96,97% -ийн үзүүлэлттэй хэрэгжилтийг ханган ажилласан. Дээрх арга хэмжээний дунд цус сэлбэлтээр дамжих халдвар болох ХДХВ, Гепатит В, С вирусын халдвар илрүүлэх нуклейн хүчил олшруулах шинжилгээг орчин үеийн аргаар хийх, аюулгүй байдлыг бүрэн хангасан цус, цусан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, өөрийн нөөц боломжийн хэмжээнд хадгалах боломж бүрдсэн[2].

Донорын тухай хууль цусны донорын үйл ажиллагаа, цус, цусан бүтээгдэхүүний нөөц хангамж, аюулгүй байдалтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор анх батлагдсан бөгөөд хуульд орсон нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгаар ихэвчлэн эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгахтай холбоотой зохицуулалтыг тусгаж ирснээс цаашид цусны донорын үйл ажиллагааг энэ хуулиар хамтад нь зохицуулах боломжгүй болсон.

Түүнчлэн Донорын тухай хуульд цусны донорын үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо, байгууллагуудын эрх, үүрэг хэт ерөнхий туссан, цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах, шинжлэх, боловсруулах, нөөц хангамжийг хариуцах болон цус, цусан бүтээгдэхүүн тээвэрлэх, хадгалах, сэлбэх эрүүл мэндийн байгууллага, анахаах ухааны боловсрол олгох боловсролын байгууллагын дэргэдэх эмнэлэг, түүний дотор цус сэлбэлт судлалын асуудал эрхэлсэн эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо, эрх, үүрэг, гүйцэтгэх чиг үүрэг тусгагдаагүй хийдэл үүссэн байна.

Цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал нь эрүүл мэндийн салбарт тавигдах гол шалгуур үзүүлэлтийн нэг байтал цус сэлбэлт судлалын харилцаанд тавих төрийн хяналт хуульчлагдаагүй байна.

Цусны донорын сургалт, сурталчилгааг Монголын улаан загалмай нийгэмлэг, бусад төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны боловсролын байгууллагатай хамтран зохион байгуулж ирсэн бөгөөд сургалт сурталчилгааны үйл ажиллагаа нийслэл хотод харьцангуй тогтвортой хийгддэг бол орон нутагт тэмдэглэлт өдрийн хүрээнд хийгдэж байна. Цусны донорыг алдаршуулах үйл ажиллагааг Монгол Улсын төрөөс байнга анхааран дэмжиж ирсэн

[2] ЦССҮТ-ийн статистик мэдээ, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай комисст хүргүүлсэн 2020 оны 02 сарын 05-ны өдрийн 59 тоот албан бичиг

бөгөөд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1962 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн ""Хүндэт донор" гэдэг энгэрийн тэмдэг бий болгох тухай" 19 дүгээр тогтоол /одоо хүчин төгөлдөр байгаа/-оор доноруудыг алдаршуулах төрийн шагнал анх бий болж олгох эрхийг нь МУЗН-ийн Гүйцэтгэх зөвлөлд өгсөн байдаг. Түүнчлэн БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 148 дугаар зарлигаар баталсан "БНМАУ-ын цол, одон, медалийн тухай дүрэм"-д "Байгалийн гэнэтийн аюул, ус, гал түймрээс хүний амь бие, улс, олон нийт, хоршоолол, иргэдийн өмч хөрөнгийг авран хамгаалах, нийгмийн хэв журам сахиулахад амь бие хайрлалгүй зүтгэж гавьяа байгуулсан хүмүүс болон хүн ардын эрүүл мэндийг хамгаалахын төлөө гавьяа байгуулсан доноруудыг" шагнахаар заасны дагуу Шударга журам медалиар шагнаж ирсэн бөгөөд, 120-оос дээш удаа цусаа бэлэглэсэн цусны донорыг "Шударга журам" медалиар шагнах Ерөнхийлөгчийн зарлиг гараад байна.

Мөн 35-аас дээш удаа цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ бэлэглэсэн Хүндэт донорыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах журмыг Эрүүл мэндийн сайд, Хүндэт донорыг рашаан сувилалд үнэ төлбөргүй амраахтай холбоотой журмыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд батлан хэрэгжүүлж ирсэн боловч эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд дараалал харгалзахгүй, үнэ төлбөргүй хамрагдах үйл ажиллагаа үндсэндээ хэрэгжихгүй байна. Манай улсын хувьд цусны донорын үйл ажиллагаа сайн дурын, авлагагүй зарчимд үндэслэдэг тул тэдэнд мөнгө биш төр, засгийн шагнал олгох хэлбэрээр алдаршуулж байх нь нэгэнт Хүндэт донор болсон бол идэвхигүй байдалд шилжиж байгаа байнгын донорын тоог дээшлүүлэхэд түлхэц болох юм.

Цусны донор, түүнд эрүүл мэндийн үзлэг хийх, цус, түүний бүрэлдэхүүн хэсэг авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, цус, цусан бүтээгдэхүүнийг хэрэглэхтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан зохицуулах, сэлбүүлэгчид тавигдах шаардлага, тэдний эрх, үүргийг шинээр хуульчлах шаардлагатай байна.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах зорилгоор удаа дараа бүрэн болон хэсэгчилсэн хөл хорионы дэглэм тогтоосноос шалтгаалан цус цуглуулалтын тоо, хэмжээ буурсан бөгөөд хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний дүнд эмнэлгийн хэрэгцээт цус, цусан бүтээгдэхүүний тасалдалгүйгээр цар тахлын хүнд үеийг даван гарч чадлаа. Гэсэн хэдий ч газар хөдлөлийн гамшиг, ослын үед богино хугацаанд цус, цусан бүтээгдэхүүний хангалттай нөөцийг бүрдүүлэхэд цусны донорын үүрэг гүйцэтгэх боломжтой хүн амыг татан оролцуулах, зохион байгуулах, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байнгын бэлэн байдалд байдаг байгууллагуудын бие бүрэлдэхүүнийг цусны донорын үүрэг гүйцэтгүүлэхтэй холбоотой зохицуулалт үгүйлэгдэж байв.

Сүүлийн жилүүдэд хүн амын дунд өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаанд зүрх судасны өвчлөл, хорт хавдар, осол гэмтэл, элэг, бөөрний эмгэг орж байгаа бөгөөд анагаах ухааны салбарт элэг, ясны чөмөг шилжүүлэн суулгах зэрэг шинэ технологиуд нутагшин эмнэлгийн тусламж, үйлчилгээний цар хүрээ нэмэгдэхийн хэрээр цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээ жил бүр өссөөр байна.

Иймд цусны донорын хөдөлгөөнийг идэвхжүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг хамгаалах, цус сэлбэлтээр дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, цусны аюулгүй байдлыг хангах, цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийг зохистой түвшинд байлгах, цус, түүний бүрэлдэхүүн хэсгээс эм,

эмчилгээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж эмчилгээнд хэрэглэж эхлэхтэй холбоотой Цусны донорын тухай хууль болон дагаж мөрдөх журмуудыг шинээр болон шинэчлэн батлах, санхүүжилт, хүний нөөц, зохион байгуулалт, бүтцийн хүрээнд цус сэлбэлт судлалын салбарт үүсч байгаа, цаашид улам хүндэрч болзошгүй зарим эрсдлийг бууруулах зайлшгүй шаардлагатай байна /График 1, 2, 3/.



График 1



График 2




График 3

Өндөр хөгжилтэй орнуудад ЦЦБ-ний 75 хувийг 65-аас дээш насны хүн амд хэрэглэдэг, бага, дунд орлоготой орнуудад 52 хувийг нь 0-5 насны хүүхдэд хэрэглэгдэг дэлхийн статистик байдаг бол манай улсын хувьд цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэгч өвчтнүүдийн 50.5 хувь нь 36-65 нас буюу ид хөдөлмөрийн насны хүмүүс байна.

Монгол улсад 2021 оны байдлаар нийт цусны донорын 74 хувь нь 40 хүртэл насны иргэд байгаа бөгөөд хүн амын суваргын хэтийн төлвөөр идэвхтэй донор /24-45 нас/-ын хүн амын тоонд эзлэх хувь 2 орчим дахин буурахаар байгаа бөгөөд дунджаар 20 орчим жил үргэлжлэх цонх үеийн цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн тасралтгүй байдлыг хангах нь бидний өмнө тулгамдсан гол асуудал болохоор байна. /График 1, 2, 3, 4/



График 4

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн орон тоо 2014 оноос хойш 20 орчим хувь[3] нэмэгдсэн байхад цус, түүний бүрэлдэхүүн хэсэг цуглуулалт, шинжилгээ, үйлдвэрлэлийн хэмжээ 2021 оны байдлаар 85-109.1 хувиар нэмэгдэн, 2035 он гэхэд дахин 210-275 хувь өсөх тооцоо[4] гарч байна. Энэ ачааллыг өнөөгийн хүний нөөцийн хэмжээгээр давах ямар ч боломжгүй байгаа төдийгүй цус сэлбэлт судлалын салбарын зохион байгуулалтыг боловсронгуй болгож, цаашид аймаг, хотуудад цусны донорын сургалт, сурталчилгаа хийх, цус, түүний бүрэлдэхүүн хэсэг авах, шинжлэх, боловсруулах, хадгалах чадавхийг дээшлүүлэх, бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангах, цус сэлбэлтээс үүдэлтэй урвал хүндрэлийг бүртгэх, хянах, цахим мэдээллийн сан ажиллуулах үүрэгтэй Цусны салбар төвүүдийг статус, дэлхий нийтээр баримтлаж байгаа “Нэгдсэн тогтолцоо”-нд үе шаттайгаар шилжих асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Ажлын хэсэг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн болон орон нутаг дахь Цусны салбар төвийн ажилтнуудаас авсан судалгаагаар Цус сэлбэлт судлалын үндэсний төв тусгай мэргэжлийн төвийн хувьд улсын төсвөөс санхүүжиж байхад Цусны салбар төвүүд орон нутгийн нэгдсэн эмнэлэгт харьяалагдаж Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих болсноор Цусны салбар төвийн эмнэлгийн мэргэжилтнүүдэд орон тоо, цалин, хөлстэй холбоотой хүндрэл үүсэх, хүний нөөцийн тогтвортой байдал алдагдах, зарим Цусны салбар төвийн өрөө, тасалгааг өөр зорилгоор ашиглахаар шилжүүлсэн байгаа нь зөвхөн цус сэлбэлт судлалын салбарт ч биш эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд сөрөг нөлөө үзүүлэх хүчин зүйл болж болзошгүй байгаа юм. Иймээс цус сэлбэлт судлалын салбарт ажилладаг эрүүл мэндийн ажилтнуудыг урамшуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх, тэдний нийгмийн асуудлыг дэмжих асуудал тулгамдаж байна.

Цусны доноруудаас авсан судалгаагаар цусны байнгын донорт дэмжлэг үзүүлэх, тэдний эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, халамжийн асуудлыг сайжруулах,

[3] ЦССҮТ-ийн хүний нөөцийн судалгаа 2014-2021 он

[4] ЦССҮТ-ийн статистик өгөгдөлд тулгуурлан регресс үнэлгээ хийсэн загварчлал

цус өгсөн донорыг илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүнээр үйлчлэх, хүн амын дунд ялангуяа оюутан, сурагчдад цусны донорын нийгмийн ач холбогдлыг таниулсан сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх, цусны донорын үйл ажиллагааг дэмжин хамтран ажилласан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулах, цусны донорын үйл ажиллагааг дэмжин зарцуулсан зардлыг нь татвараас чөлөөлөх зэрэг цусны нөөц хангамжийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчин бий болгох, үндэсний аюулгүй байдалтай холбоотой онцлог салбарын хувьд төрөөс цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн талаар онцгойлон анхаарах шаардлагатай байна.

**1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох**

Хуулийн төсөлд дараах бүлгийн эрх ашиг хөндөгдөнө.

| № | Эрх ашиг нь хөндөгдөж буй бүлэг | Тэдний эрх ашгийн сонирхолд ямар байдлаар нөлөөлж байгаа |
|---|---|---|
| 1 | Иргэд | Төсөлд цусны донор, цус сэлбүүлэгч гэсэн субьектийг тодорхойлж өгсөн ба нэг талаас бусдын амь нас, эрүүл мэндийг аврахын тулд энэ харилцаанд сайн дураараа оролцогч болох, нөгөө талаас өөрөө энэ төрлийн эмчилгээ үйлчилгээ авахыг хүссэн, эсхүл эмчилгээний заалтаар цус сэлбүүлэх зайлшгүй шаардлагатай болсонтой холбоотой эрх үүргийн харилцаа үүсч байгаа болно.<br>Цусны донорын эрх, үүрэг, тэдэнд тавигдах шаардлагыг тодорхой болгож, тэднийг алдаршуулах, урамшуулах, нийгмийн дэмжлэг, баталгааг сайжруулснаар тэдний идэвхи дээшилж, байнгын донорын тоо тогтвортой дээшилнэ.<br>Нөгөө талаар сэлбүүлэгчид тавигдах шаардлага, эрх үүргийг тодорхойлж өгснөөр цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлэгч (иргэн хүн) эрүүл саруул болж амь нас нь аврагдах, цаашилбал нийгэмдээ идэвхтэй байр сууль эзэлж, ажил хөдөлмөр эрхлэн баялаг бүтээгч болох боломж нээгдэнэ. |
| 2 | Аж ахуйн нэгж байгууллага | Цусны донорын ач холбогдлын талаар сургалт зохион байгуулах, сурталчлах, оюутан, сурагчдад эрүүл аж төрөх ёс, цусны донорт тавигдах шаардлагын талаар сургалт зохион байгуулахад оролцох байгууллага, цусны донорт эмнэлгийн үзлэг хийх, түүнээс цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, өвчтөнд сэлбэх эрх бүхий эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага, тэдгээрийн тогтолцоо, эрх үүргийг тодорхойлсноор нь өвчтөн /иргэн/-ий эрүүл мэнд, амь насыг аврах үйл хэргийг хэрэгжүүлэх таатай нөхцөл боломжийг |

| | | |
|---|---|---|
| | | бүрдүүлснээр энэ оролцогч этгээдийн эрх ашигт нийцэж, өөрсдийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд нөлөөлнө.<br><br>Түүнчлэн цусны донорын үйл ажиллагааны тогтолцоо, салбар хоорондын хамтын ажиллагаа, төрийн хяналт хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. Нөгөө талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудыг цусны донорын хөдөлгөөнд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд оролцох харилцааг тодорхойлж өгснөөр цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн тасралтгүй байдал хангагдах, аж ахуйн нэгж байгууллагыг цусны донорын хөдөлгөөнийг идэвхижүүлэх, цусны донорыг алдаршуулах, урамшуулахад зарцуулсан зардлыг татвараас чөлөөлөх боломжийг бүрдүүлснээр сургалт, сурталчилгааны ажил сайжрах, цусны донор ажилтнууддаа дэмжлэг үзүүлэх замаар эрүүл аж төрөх ёсыг дэлгэрүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх бодлогын хэрэгжилт, аж ахуйн нэгж, байгууллагуудын нийгмийн хариуцлагыг нэмэгдлүүлэхэд дэмжлэг болох юм. |
| 3 | Төр, төрийн албан хаагч | Хуулийн төсөл болон дагаж гарсан журам удирдамжаар энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлж буй эмч эмнэлгийн мэргэжилтний эрх ашиг, үүрэг, оролцоо, тэдний цалин, хөлс нэмэгдэх, нийгмийн баталгаа хангагдах, цус сэлбэлт судлалын үйл ажиллагаа шинжилэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл болсноор эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх боломж нэмэгдэнэ. |

Эдгээр эерэг үр дагавар үүсгэх нөлөөллийн улмаас цусны донорын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангаар дамжуулан өвчтөнд тохирсон, эмчилгээний үр дүнтэй цус хуваарилаж, сэлбэх зэрэг харилцаа хуулийн дагуу явагдах боломж бүрдэнэ.

**1.3 Асуудлыг үүсгэж байгаа шалтгаан, нөхцлийг тогтоох;**

Цусны донорын тухай хуулийг шинээр боловсруулах болсон шалтгаан нь сүүлийн 20 жилийн хугацаанд Донорын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдээр манай улсад нутагшуулж байгаа эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний шинэ технологиудтай холбоотой эрх зүйн зохицуулалтуудыг бий болгох зорилтыг шийдэж ирснээс ард иргэдэд сурталчлах, таниулах, алдаршуулж, урамшуулах зайлшгүй шаардлагатай цусны донорын үйл ажиллагааг Эрхтний наймаа болон эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний туризмын эсрэг тунхаглал[5] -аар баталсан нийтэд сурталчлах нь эд эрхтэн шилжүүлэх жуулчлал бий болох, хөгжих үндэс болдог тул уг хэрэгт татан оролцуулахаас хориглох стратегитай зөрчилддөг харилцааг хамтад нь зохицуулах боломжгүй болж, зарим талаар цусны донорын үйл ажиллагааг зохицуулсан харилцаа ойлгомжгүй, эсхүл эд эрхтний наймаа бий болох эрсдлээс сэргийлсэн харилцаанд хамрагдах зэргээр хэт хүндрэлтэй болсон байна.

[5] Турк, Истанбул хот, 2008 оны 5 дугаар сард батлагдсан.

Одоогийн хууль тогтоомжоор үүссэн давхардал, хийдэл, зөрчлийг 2 өөр хууль болгох замаар дараах байдлаар шийдвэрлэх шаардлага үүсээд байна:

1. Цусны донорын үйл ажиллагаа болон цус сэлбэлт судлалын үйл ажиллагаанд баримтлах зарчмыг дэлхий нийтийн хандлага, үндсэн хууль, бусад хуультай нийцүүлэн тодорхойлох;
2. Цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал нь эрүүл мэндийн салбарт тавигдах гол шалгуур үзүүлэлтийн нэг байтал цус сэлбэлт судлалын харилцаанд тавих төрийн зохицуулалт, хяналт тодорхой бус байна. Цус сэлбэлт судлалын асуудал эрхэлсэн тусгай мэргэжлийн төвд цус, цусан бүтээгдэхүүн хэрэглэгч эрүүл мэндийн байгууллага, цусны салбар төвийн үйл ажиллагаанд хяналт тавих орон тоо батлагдаагүй, эмнэлгийн тусгай зөвшөөрөлд цус, цусан бүтээгдэхүүн хэрэглэх эрхийг тусгадаггүйгээс тэдний гэрээ байгуулахаар ирүүлж байгаа материалын бүрдлээр хяналт тавих, төрөлжсөн мэргэшил эзэмшсэн эмнэлгийн мэргэжилтэнтэй эсэхийг хянахаас хэтрэх боломж бүрдээгүй байна. Иймд цусны аюулгүй байдал, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор тусгай зөвшөөрлийн, цус сэлбэлтийн дараах урвалж, хүндрэлийн, мэдээллийн сангийн хяналтуудыг оруулах;
3. Цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамж, бэлэн байдал нь үндэсний аюулгүй байдлыг хангахад нөлөөлөх нэг хүчин зүйл болдог тул цусны донорын үйл ажиллагаан дахь Засгийн газрын бүрэн эрхийг тодорхойлох шаардлагатай. Үүний дотор “Хүндэт донор” тэмдэгийг хуульчлан Засгийн газар олгодог болгох байдлаар цусны доноруудад үзүүлэх хүндэтгэл, үнэлэмжийг сайжруулан алдаршуулах;
4. Цусны донорын үйл ажиллагаанд хамаарах байгууллага, тэдгээрийн удирдлагын тогтолцоо, харилцаанд оролцогч байгууллага, Нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргын эрх үүргийг тодорхойлж, бусад байгууллагын хүрээг тусдаа эрх зүйн зохицуулалттай төрийн цэргийн байгууллагын болон цагдаагийн байгууллагыг оролцуулан өргөжүүлэх;
5. Санхүүжилтийн тогтолцоог цус донорын сургалт, сурталчилгаа, цусны донорт олгох илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүн, цус, түүний бүрэлдэхүүн хэсэг авах, шинжлэх, цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, олгох, цус сэлбэлт судлалын салбарын ажилтны цалин, хөлс, нийгмийн асуудлыг дэмжихэд зарцуулах төсвийг тодорхойлж өгөх, цусны донорын үйл ажиллагааг дэмжин хамтран ажилласан төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулах, цусны донорын үйл ажиллагааг дэмжин зарцуулсан зардлыг нь татвараас чөлөөлөх зэрэг цусны нөөц хангамжийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчин бий болгох;
6. Цусны донор, түүнд тавигдах шаардлага, эрүүл мэндийн үзлэг хийх, цус, түүний бүрэлдэхүүн хэсэг авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, цус, цусан бүтээгдэхүүнийг хэрэглэхтэй холбоотой зохицуулалт, сэлбүүлэгч, цусны донорын харилцаанд оролцогч эмнэлгийн мэргэжилтэнд тавигдах шаардлага, тэдний эрх, үүргийг нарийвчлан тодорхойлох;
7. Цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах, шинжлэх, боловсруулах, нөөц хангамж хариуцах эрүүл мэндийн байгууллагыг цус, цусан бүтээгдэхүүн

хэрэглэгч эрүүл мэндийн байгууллагатай ялгамжтай болгох, цус, цусан бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааг хуульчлах;

8. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийг зохицуулалт, гамшгийн үед цусны донорын харилцаанд татан оролцуулах субьектыг тодорхойлж, шаардлагатай хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах;
9. Цусны донорын мэдээллийн сангийн эр зүйн зохицуулалтыг бий болгох, ингэхдээ мэдээллийн аюулгүй байдлын талаарх хууль тогтоомж, цус сэлбэлт судлалын үйл ажиллагааны онцлог, цусны донорын талаарх мэдээллийн ач холбогдолтой уялдуулан нийцүүлэх, мэдээллийн санг ажиллуулах байгууллагыг тодорхойлох;
10. Цусны донорын хөдөлгөөнийг идэвхжүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг хамгаалах, цус сэлбэлтээр дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, цусны аюулгүй байдлыг хангах, цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийг зохистой түвшинд байлгах зорилгоор цусны донорын үйлсийг сурталчлах, цусны донорт элсүүлэхэд оролцох байгууллагыг тодорхойлох, холбогдох сургалтын байгууллагуудын хөтөлбөрт цус донорын нийгмийн ач холбогдол, эрүүл аж төрөх ёсны сургалтыг тусгах, тэднийг алдаршуулах, урамшуулах үйл ажиллагаа, хариуцах байгууллага, цусны донор, Хүндэт донорт үзүүлэх дэмжлэгийг тусгах;
11. Хариуцлагын асуудлыг тодорхойлох.

## ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 4-д заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

**Асуудлыг шийдвэрлэх зорилго нь:** Цус сэлбэлт судлалын үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомж, баримтлах зарчим, түүнд тавих төрийн хяналт, цус сэлбэлт судлалын харилцаанд хамаарах этгээд, түүний удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн үндэс, санхүүжилт, эрх, үүрэг, цусны донор, сэлбүүлэгч, тэдэнд тавигдах шаардлага, эрх үүрэг, эрүүл мэндийн үзлэгт хамрагдах, цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ үнэ төлбөргүй өгөх, түүнийг шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, өвчтөнд сэлбэхтэй холбоотой харилцаа, цус, цусан бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа болон уг үйл ажиллагаатай холбоотой үүсэх төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэний эрх, үүргийг тодорхойлохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

<u>Зорилт 1:</u> Цусны донорын үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох;

<u>Зорилт 2:</u> Цусны донорын үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчмыг тодорхойлох;

<u>Зорилт 3:</u> Цусны донорын үйл ажиллагаан дахь салбар хоорондын хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах;

<u>Зорилт 4:</u> Цусны донорын үйл ажиллагаан дахь зохион байгуулалтыг тодорхойлох;

Зорилт 5: Цусны донорын үйл ажиллагааны хүрээнд төр, иргэн, хуулийн этгээд, холбогдох мэргэжлийн байгууллагын эрх, үүргийг тодорхойлох;

Зорилт 6: Цусны донорын үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулах, хяналтын тогтолцоог тодорхойлох.

## ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫГ ТОГТООЖ, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 5.1 дүгээр зүйлд зааснаар асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулан үзэх ажлын хүрээнд дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх зорилгыг биелүүлэхэд чиглэсэн хувилбаруудыг тогтооно.

| № | Хувилбар | Зорилгод хүрэх байдал | Зардал, үр өгөөжийн харьцаа | Үр дүн |
|---|---|---|---|---|
| 1 | “тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах; | Зорилгод хүрэх боломжгүй | Зардал гаргасан, гаргаагүй аль ч тохиолдолд үр өгөөж гарахгүй, зах зээлийн механизм үйлчлэх боломжгүй. | Үр дүнд хүрэхгүй. |
| 2 | хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх; | Зорилгод бүрэн хүргэхгүй. Энэ хувилбарыг одоо ч хэрэглэж байгаа бөгөөд зорилгод хүрэх үйл ажиллагааны зөвхөн нэг тал бөгөөд цус сэлбэлт судлалын байгууллагуудын үйл ажиллагааг өргөжүүлэхэд шаардлагатай зохион байгуулалт бий болгох, тэдний эрх үүргийг зааглах, ижил тэгш оролцоог хангах боломжгүй. | Тодорхой зардал гарах боловч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгаан, нөхцөлийг арилгаж, бууруулж чадахгүй. | Үр дүнд хүрэхгүй. |
| 3 | зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх; | Зорилгын тодорхой хэсэг, тухайлбал, цусны донорын алдаршуулалт, урамшуулалд оролцох хүсэлтэй аж ахуйн нэгжүүдийг идэвхижүүлэх, донорыг урамшуулахад зарим нэг үр дүн үзүүлэх боловч үндэсний аюулгүй байдалтай холбоотой стратегийн бүтээгдэхүүн болох цус, цусан бүтээгдэхүүнийг бизнесийн | Тодорхой зардал гарах хэдий ч үр өгөөж бага, сөрөг үр дагавартай | Үр дүнд хүрэхгүй. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | зарчмаар ашиг олох хэрэглүүр болгох нь зохимжтой биш бөгөөд нийтлэг байдлаар үр дүнд хүрэхэд хангалттай биш. | | |
| 4 | Төрөөс санхүүгийн интервенц хийх; | Төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх тохиолдолд хүний нөөц, техник, технологийг бэхжүүлэх боломжтой ч зорилгыг бүрэн хамарч, тогтвортой түвшинд хүрч чадахгүй. | Тодорхой зардал гарах бөгөөд харин үр өгөөж нь хүний нөөц, техник, технологийг л бэхжүүлнэ. | Үр дүнд хүрэхгүй. |
| 5 | Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх; | Зорилгын тодорхой хэсэг, тухайлбал, цусны донорын сургалт, сурталчилгааг МУЗН, МДХ зэрэг төрийн бус байгууллагатай, цусны донорын алдаршуулалт, урамшууллыг МУЗН, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг бөгөөд цус сэлбэлт хийх эрх бүхий хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай цус, цусан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулан ажилладаг.<br>Гэвч цус сэлбэлт судлалын харилцаанд оролцогчдын үйл ажиллагаа нь тухайн салбарын хууль, тогтоомжоор зохицуулагдаж байдаг тул нийтлэг байдлаар үр дүнд хүрэхэд хангалттай биш. | Тодорхой зардал гарах хэдий ч үр өгөөж бага | Үр дүнд хүрэхгүй. |
| 6 | Захиргааны шийдвэр гаргах; | Энэхүү хувилбараар зорилгын тодорхой асуудлыг зохицуулж болох хэдий ч тэдгээр шийдвэрийн эрх зүйн байдлыг хуулиар тогтоогүй тул тодорхой хангалттай нөхцөл болж чадахгүй. Тухайлбал, цус сэлбэлт судлалын салбар дахь төрийн хяналт, зохион байгуулалт, нэгдсэн удирдлага, төлөвлөлт, | Зорилгын тодорхой хэсгийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар зохицуулж байгаа ч эдгээр шийдвэрийн үр өгөөж эрүүл мэндийн салбарын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд бүрэн зохицуулагдахад учир дутагдалтай байх талтай ба асуудлыг | Үр дүнд хүрэхгүй. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | зохицуулалтын тогтолцоо, түүний тогтвортой байдалтай холбоотой зорилгыг бүрэн шийдвэрлэж чадахгүй. | үүсгэж байгаа шалтгааныг бүрэн арилгаж чадахгүй | |
| 7 | Хууль тогтоомжийн төсөл боловсруулах. | Энэхүү хувилбар нь зорилгыг бүрэн зохицуулах боломжтой | Тодорхой хэмжээний зардал гарах болович үр өгөөж нь өндөр байна. Үр ашиггүй, давхардсан хөрөнгө оруулалт байхгүй болох, цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийн тасралтгүй байдал хангагдах нөхцөл бүрдэнэ. | **Үр дүнтэй** |

Дээрх харьцуулалтаас харахад зөвхөн “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбар үр дүнтэй харагдаж байна. Иймд хуулийн төслийн агуулга, зохицуулалтын хэлбэрийг өмнө тодорхойлсон зорилгын дагуу дараах байдлаар ерөнхийлөн томьёолж байна:

Тус хуулиар хүний эрүүл мэндийг хамгаалах, амь насыг нь аврах зорилгоор сайн дураараа эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж, цус, түүний бүрэлдэхүүн хэсгээ авлагагүйгээр бэлэглэх, түүнийг шинжлэх, үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, өвчтөнд сэлбэх, эдгээртэй холбоотой аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа болон уг үйл ажиллагааны талаарх төрийн бодлого, зохицуулалт, баримтлах зарчим, хэрэгжүүлэх байгууллагын эрх зүйн үндэс, цус сэлбэлт судлалын салбарын харилцаатай холбогдон үүсэх төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэний эрх, үүргийг зохицуулсан хууль тогтоомжийн төсөл боловсруулах нь үр дүнтэй байна.

## ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6 дугаар зүйлд заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг Аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хавсралтаас үзнэ үү.

### 4.1. Хүний эрхэнд үзүүлэх үр нөлөө

Цусны донорын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн боловсруулна. Ийнхүү боловсруулснаар талуудын эрх үүрэг, хариуцлага тодорхой болох бөгөөд хэн нэг нь зөрчигдсөн эрхээ сэргээлгэх хууль эрх зүйн орчин цогцоор бүрдэх юм.

Иймд эдгээр асуудлыг цогцоор шийдвэрлэхийн тулд хуулиар зохицуулах нь илүү үр нөлөөтэй байна.

**4.2 Эдийн засагт үзүүлэх үр нөлөө**

Цусны донорын тухай хуулийг боловсруулах хувилбар нь аж ахуйн нэгж, байгууллага дэлхийн болон дотоодын зах зээл дээр өрсөлдөх чадвар, тогтвортой байдал, тэдний үйлдвэрлэлийн болон захиргааны зардал, макро эдийн засгийн хүрээнд, мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал, өрхийн орлого зарлага, олон улсын харилцаа зэрэгт сөрөг нөлөө үзүүлэхгүй нь Аргачлалын 6.2-т заасан эдийн засагт үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт /хавсралт хүснэгт 2/-аас харагдаж байна.

**4.3 Нийгэмд үзүүлэх үр нөлөө**

"Хуулийн төсөл боловсруулах" хувилбарын хувьд Аргачлалын 6.2-т заасан нийгэмд үзүүлэх үр нөлөөний суурь асуултын хариулт /хавсралт хүснэгт 3/-аас харахад нийгэмд үзүүлэх ямар нэг сөрөг нөлөө байхгүй ба төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид эерэгээр нөлөөлнө.

**4.4 Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө**

Хувилбар нь байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй. /Хавсралт хүснэгт 4/

**4.5 Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх**

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа болно.

## ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хувилбарын эерэг болон сөрөг талуудыг зорилгод хүрэх байдал, зардал, үр өгөөжийн харьцаа, хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж буй эсэх гэсэн шалгуураар дахин нягталж үзэж, хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа 2 дугаар хэсэгт тодорхойлсон зорилгыг хангах, 3 дугаар хэсэгт ерөнхийлөн томьёолсон хуулийн төслийн агуулга, зохицуулах харилцааны хүрээнд Цусны донорын тухай анхдагч хуулийн төсөл боловсруулж, асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж дүгнэлээ.

Хуулийн төсөл батлагдаж, хэрэгжсэнээр дараах эерэг үр дүн гарах боломжтой гэж дүгнэв. Үүнд:

1. Цусны донорын үйл ажиллагаан дахь төрийн зохицуулалт, хяналт сайжрах

2. Цусны донорын харилцаанд оролцогч байгууллагууд, үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо, харилцаанд оролцогч талууд, түүний дотор цусны донорны үлй ажиллагаа хариуцсан байгууллага, цусны салбар төв, нутгийн өөрөө удирдах байгууллага, засаг дарга, төрийн цэргийн болон цагдаагийн байгууллагын эрх, үүрэг тодорхой болох;

4. Санхүүжилтийн тогтолцоо боловсронгуй болсноор цусны донорт үзүүлэх дэмжлэг, цус сэлбэлт судлалын салбарт ажиллагсадын цалин, нийгмийн асуудал

сайжрах, аж ахуйн нэгжүүдийн цусны донорын үйл ажиллагааг дэмжин оролцох сонирхол нэмэгдэх

5. Цусны донор, сэлбүүлэгч, цус сэлбэлт судлалын салбарын эмнэлгийн мэргэжилтэнд тавигдах шаардлага, тэдгээрийн эрх, үүрэг тодорхой болох

6. Донороос цус, түүний бүрэлдэхүүн хэсэг авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, сэлбэх, устах үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын оролцоо, ялгааг тодорхой болгох

7. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед цусны донорын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зохицуулалт бий болгох

8. Цусны донорын мэдээллийн сан бий болгох, ажиллуулах, бүрдүүлэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлох

9. Цусны донорын алдаршуулалт, урамшуулалт, тэдгээрт үзүүлэх дэмжлэгийг сайжруулах зэрэг үр дүн гарна.

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэгт заасны дагуу Цусны донорын тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Донорын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төсөл тус тус боловсруулна.

## ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Хуулийн төсөл боловсруулах хувилбар сонгогдсон тохиолдолд Аргачлалын 8-д заасны дагуу олон улсын эрх зүйн зохицуулалт, бусад орны адил төстэй эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх зорилгоор дараах улсуудад Цусны донорын тухай хуулийн зохицуулалтын асуудлыг хэрхэн хуульчилсан байдлыг судаллаа.

ДЭМБ-ын 2018 оны мэдээгээр Цусны алба бүхий 171 улсаас 123 улс нь Үндэсний бодлоготой, 110 улс нь Цус сэлбэлтийн аюулгүй байдал, чанарыг зохицуулах тусгай хуультай байна.

Дэлхийн олон улс орнуудад эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах болон цусны донорын үйл ажиллагааг тусад нь хуульчилсан байдаг. Цусны донорын тухай хуулиараа цус, цусан бүтээгдэхүүний нөөц хангамжийн тогтвортой, аюулгүй байдал, цусны донорын хөдөлгөөний нийгмийн ач холбогдлыг ард иргэдэд таниулах, сурталчлах замаар цусны донорын эгнээг өргөжүүлэх чиглэлээр төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх болон цус сэлбэлт судлалын харилцаанд оролцогч этгээдүүдийн эрх, үүрэг, эдгээрийг удирдан зохион байгуулах болон гүйцэтгэх байгууллагуудын эрх зүйн зохицуулалт, цусны донорт тавигдах шаардлага, эрх, үүргээс гадна цусны донорт эрүүл мэндийн үзлэг хийх, цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах, шинжлэх, үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, эмчилгээний зорилгоор хэрэглэх үйл ажиллагаа, эдгээрт оролцогч эрүүл мэндийн байгууллага, тэдгээрийн тусгай зөвшөөрөл, мэдээллийн нэгдсэн сан, санхүүжилт, төрийн болон төрийн бус байгууллагын түншлэлийн асуудлыг зохицуулдаг.

## ГҮРЖ УЛС

Гүрж улс нь Цусны донорын тухай хуультай. Уг хууль нь Гүрж улсад нийгэм, эдийн засаг, хууль эрх зүй, эрүүл мэндийн арга хэмжээг хэрэгжүүлэн, донорын эрхийг хамгаалж, цусны донор, цус сэлбэлт судлалын судлалыг салбарыг хөгжүүлэх зорилготой.

Цусны донор сайн дурын байх зарчимтай бөгөөд 18-65 насны, эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан, цус өгөх эсрэг заалтгүй, иргэн бүр цусны донор байж болдог. Иргэн даатгалд хамрагдан өөрийн цусыг хадгалуулах зорилгоор, цусаа хандивлах болон төрөл төрөгсөддөө төлбөртэй хэрбээрээр өгч болох зохицуулалттай.

Цусны донорын хөдөлгөөнийг хөгжүүлэх Засгийн газрын хөтөлбөртэй. Уг хөтөлбөрийг цус цусны донорын хөдөлгөөнийг идэвхжүүлэх, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэгтэй Хөдөлмөр, эрүүл мэнд, нийгмийн хамгааллалын асуудал эрхэлсэн яамны дэргэдэх Зохицуулалтыг алба хариуцдаг бөгөөд ажиллах журмыг нь Гүрж улсын эзлэгдсэн нутаг дэвсгэрээс нүүлгэн шилжүүлсэн иргэд, хөдөлмөр, эрүүл мэнд, нийгмийн асуудал хариуцсан сайд баталдаг байна.

Цус сэлбэлт судлалыг хөгжүүлэх, зохион байгуулах, сурталчлах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шаардлагатай цусан бүтээгдэхүүний хэрэгцээг хангах санхүүжилтийг төрөөс болон хандиваар шийдвэрлэдэг.

Орон нутгийн засаг захиргаа нь өөрийн нутаг дэвсгэртээ цусны донорын хөдөлгөөнийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэргжүүлэх үүрэгтэй. Цусны донорын хөдөлгөөнийг зохион байгуулахад төрийн болон ахуйн нэгж байгууллага, байгууллагын удирдлага өмчийн хэлбэр харгалзахгүйгээр дэмжиж, идэвхтэй оролцох, хөрөнгө гаргах үүрэг хүлээдэг. Гүржийн Улаан загалмай нийгэмлэгийн салбар, байгууллагууд өөрсдийн болон олон улсын холбогдох дүрэм, журмын дагуу сайн дурын авлагагүй донорыг эгнээг өргөжүүлэхэд идэвхтэй оролцох үүрэгтэй. Олон нийтийн байгууллага, холбоод нь сайн дурын цусны донорын сургалт, сурталчилгаа, цус цуглуулах үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүжүүлэх, сурталчлах үүрэгтэй.

Аж ахуйн нэгж, байгууллагын дарга (өмчийн хэлбэрээс үл хамааран), цэргийн байгууллагын удирдлага урьдчилан тохиролцсоны үндсэн дээр ажилтан, албан хаагч, оюутан, хөдөө аж ахуйн салбарын ажилтан, цэргийн албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамрагдах ба цусны төвд очиж цусаа өгөх өдөрт нь чөлөө өгөх, тэр өдрийн цалин хөлс бусад материаллаг урамшууллыг Гүрж улсын хууль тогтоомжийн дагуу олгох, цусаа өгсний дараа цусны донорт өөрийн хүсэлтээр нь нэмэлт амралтыг өдөр олгох, энэхүү амралтыг өдрийг 1 жилийн хугацаанд ээлжийн амралт дээр тооцож олгох, эсхүл үндсэн цалингийн хэмжээгээр нэмэлт амралтын өдрийн цалинг олгох, цусны донор ээлжийн амралт болон ажлын бус өдөр цусаа өгсөн тохиолдолд өөр өдөр амраах, хэрэв өөр өдөр амраагаагүй бол цусаа өгсөн өдрийн цалинг хоёр дахин нэмэгдүүлж олгох, цус цуглуулах явуулын багт дэмжлэг үзүүлэн, цус авахад шаардлагатай өрөө тасалгаагаар хангах үүрэгтэй байна.

Оюутан, сурагчдыг цусны донорын асуудалд зөв хандлагыг /чиглүүлэх/ төлөвшүүлэхийн тулд Гүржийн Боловсрол, шинжлэх ухаан, соёл, спортын яам нь цусны донорын ач холбогдол, цусны донорын аюулгүй байдлын талаарх мэдээллийг ерөнхий боловсролын болон их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгадаг байна.

Төрөөс цусны донорын эрхийг хамгаалах, эрүүл мэндийг нь хамгаалах баталгааг хангахаас гадна тэтгэмж олгодог. Цусны донор нь донорын үүргийг гүйцэтгэж байхдаа халдварт өвчин туссан, эрүүл мэндэд нь хохирол учруулсан тохиолдолд ашиглах цусны албаны зардлаас санхүүждэг албан журмын даатгалд хамрагддаг. Даатгалын зардал нь цусны өртгөгт орсон байдаг байна. Цусны донор нь ажиллаж байгаа байгууллагын удирдлагатай тохиролцсоны дагуу аль ч өдөр цус сэлбэх байгууллагад очиж эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж, цусаа өгөх, цусаа өгсний дараа нэмэлт амралт авах, маргааш нь ашиглах, энэ өдрийг ээлжийн амралтдаа нэмж эсвэл цусаа өгсний дараа жилийн аль ч үед эдлэж болох, цэргийн албан хаагч цусны донорын хувьд цус өгсөн өдөр ээлж, харуул манааны болон цэргийн албаны бусад үүргийг гүйцэтгэхээс чөлөөлөгдөх эрхтэй байдаг.

Цусны донор нь эрүүл мэндийн үзлэгт хамрагдахдаа өвчилсөн бүх өвчний талаар, түүнчлэн мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн мэдээллийг үнэн зөв өгөх үүрэгтэй бөгөөд энэ мэдээллээ санаатайгаар нуун дарагдуулсан, гуйвуулсан иргэн Гүрж улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээдэг байна.

Сайн дурын авлагагүй цусны донорын тогтолцоог идэвхжүүлэх зорилгоор цус эсвэл сийвэн өгсөн нийт дүнгээр 4 бүлэгт хувааж алдаршуул, урамшуулдаг байна:

а) Гуравдугаар зэрэглэл: гурав ба түүнээс дээш удаа цус, цусны сийвэн өгсөн, жилд нэгээс доошгүй удаа цусаа өгсөөр байгаа цусны донор;

б) Хоёрдугаар зэрэглэл: 3-5 литр цус эсвэл 10-15 литр сийвэн өгсөн донор;

в) Нэгдүгээр зэрэглэл: 10-20 литр цус эсвэл 15-20 литр сийвэн өгсөн донор;

г) Хүндэт донор: 20 литрээс дээш цус, 30 литрээс дээш сийвэн өгсөн донор.

Гүржийн Засгийн газрын тогтоолоор батлагдсан "Гүрж улсад цусаа бэлэглэхийг дэмжих арга хэмжээний тухай журам" -аар тогтоосон нийгмийн баталгаа, тэтгэмжийг төрөөс бүлэг тус бүрийн донорт олгодог ба энэхүү тэтгэмж нь хууль батлахаас өмнө цус, сийвэн өгсөн доноруудад мөн хамаардаг.

Гуравдугаар зэрэглэлийн донорын гэрчилгээг /тэмдэг/ цусны төв, хоёрдугаар зэрэглэлийн донор цолыг цус сэлбэлт судлалын Үндэсний төв байгууллагын тодорхойлолтыг үндэслэн Хөдөлмөр, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам нэгдүгээр зэрэглэлийн донорын цолыг Хөдөлмөр, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамнаас олгодог бол Хүндэт донор цолыг Гүржийн Хөдөлмөр, эрүүл мэнд, нийгмийн асуудал эрхэлсэн сайдын тушаалаар олгодог байна.

Эрүүл мэндийн байгууллагууд эмнэлзүйн цус сэлбэлтийг /трансфизиологи/ үйл ажиллагааг зөв зохион байгуулж, цус цусан бүтээгдэхүүний хэрэгцээг тодорхойлж, донорын тоог нэмэгдүүлэхэд бүхий л хүчин чармайлт гаргаж, төрөл төрөгсдийг донорт татан оролцуулах, донорыг үйлсийг идэвхтэй сурталчлах, цусны донорын эрүүл мэндийг хамгаалах үүрэгтэй байдаг.

Донорын цуснаас цус цусан бүтээгдэхүүнийг бэлтгэх, хадгалах, ашиглах журмыг зөрчсөн тохиолдолд эрүүл мэндийн байгууллагын ажилтан, албан тушаалтнууд Гүрж улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээдэг байна.

Байгалийн гамшиг, осол, сүйрэл, цар тахал болон бусад онцгой байдлын үед Гүрж улсын нутаг дэвсгэр даяар эсвэл тухайн нутаг дэвсгэрт цус, цусны бүрэлдэхүүн цуглуулах донорын зохион байгуулалтыг тогтоосон журмын дагуу, Гүржийн хөдөлмөр, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын удирдлага дор явуулдаг бөгөөд энэ тохиолдолд цус, түүний

бүрэлдэхүүн хэсгүүдийг хандивлах ажлыг зохион байгуулахад шаардагдах бүх санхүүжилтийг Гүржийн улсын нөөцийн сангаас, түүнчлэн орон нутгийн засаг захиргааны нөөцийн сангаас гаргахаар хуульчилсан байна. Мөн цус сэлбэлт судлалын чиглэлийг шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл гэж үздэг ажээ.

## ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

Өнөөгийн байдлаар 2012 онд батлагдсан Цусны донорын тухай хуулийг даган мөрдөж байгаа бөгөөд Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгахтай холбоотой харилцааг өөр хуулиар зохицуулдаг байна.

Цусны донорын тухай хуулиар донороос цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, түүний аюулгүй байдлыг хангах, эмчилгээнд хэрэглэх, түүнчлэн цус, түүний бүрэлдэхүүн хэсгийн донор, сэлбүүлэгчийн эрүүл мэнд, эрхийг хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах зорилгоор цус, түүний бүрэлдэхүүн хэсгийн донорын хөдөлгөөнийг хөгжүүлэхэд чиглэсэн эрх зүй, эдийн засаг, нийгмийн зохицуулалтын үндсийг тогтоон хэрэгжүүлдэг бөгөөд цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг хариу төлбөртэй болон төлбөргүйгээр авах, ауто донорын харилцаа, цусны донорын алдаршуулалт, нийгмийн халамжийг ялгавартай тогтоосон байдаг.

Мөн сайн дураар цусны донор болох хүсэлтэй 18 нас хүрсэн иргэн /18 нас хүрээгүй боловч эрх зүйн бүрэн чадамжтай болсон иргэн/, гадаадын иргэн, харьяалалгүй хүн /1 жил байнга оршин суусан/ тус улсын иргэн өөрөө цусны донор болох хүсэлтээ илэрхийлж болохоор байдаг бөгөөд зөвхөн улсын эмнэлэг, эрүүл мэндийн боловсрол олгодог боловсролын байгууллага болон цэргийн байгууллага цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах эрхтэй байдаг. Цусны донорт Засгийн газраас Хүндэт донор энгэрийн тэмдэг шагнаж, насан туршид нь жил бүр инфляц болон бусад хүчин зүйлийг харгалзан тогтоосон индексээр шинэчлэгддэг мөнгөн урамшуулал, бусад халамж үзүүлдэг байна.

Цус, цусан бүтээгдэхүүнийг эрүүл мэндийн баталгааг нь хангасан бүлэг /цэргийн болон түүнтэй адилтгах байгууллага зэрэг/-т үнэ төлбөргүй олгож, зардлыг нь Засгийн газар хариуцдаг бол бусад тохиолдолд төлбөртэй үйлчилгээнд хамруулдаг зохицуулалттай байна.

## БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС

БНХАУ-ын Цусны донорын тухай хууль нь анагаах ухааны болон эмнэлзүйн салбарт цус, цусан бүтээгдэхүүнийг хэрэглэх шаардлага ба цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, зохистой хэрэглээг хангах, цусны донор болон сэлбүүлэгчийн эрүүл мэндийг хамгаалах, хүнлэг, энэрэнгүй нийгмийг дэмжих, ухаалаг нийгэм болон нийгмийн социалист үзлийг бий болгох зорилготой бөгөөд төрөөс 18-25 насны харьцангүй эрүүл хүн амыг сайн дурын үндсэн дээр авлагагүй цусны донор болохыг дэмждэг байна.

Цусаа хандивлах нөхцлийг бүрдүүлэх, нэгдсэн төлөвлөлт хийж зохион байгуулах ажлыг орон нутгийн бүх шатны засаг захиргааны байгууллага өөрийн нутаг дэвсгэрийн хамрах хүрээнд зохион байгуулж, улсын болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын нийгмийн эрүүл мэндийн хэлтэс цусаа хандивлах ажлыг удирдан явуулах бөгөөд хяналт тавидаг, үүнд бүх шатны Улаан загалмайн

нийгэмлэгүүд хуульд нийцүүлэн цусаа бэлэглэх ажлыг дэмжин, хамтран оролцдог байна.

Цусаа хандивлахын ач холбогдлыг сурталчлах болон цус өгөлтийн талаар шинжлэх ухааны мэдлэг, цус өгөх үеийн хяналт болон сэргийлэлт, цус сэлбэлтээр дамжих халдвараас хэрхэн сэргийлэх талаарх мэдээллийг ард иргэдэд түгээх арга хэмжээг бүх шатны засаг захиргааны байгууллага хэрэгжүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь цус хандивлах талаар нийгэмд чиглэсэн ашгийн бус сурталчилгаа явуулах үүрэгтэй байдаг байна. Түүнчлэн төрийн байгууллага, зэвсэгт хүчин, нийгмийн бүлгүүд, аж ахуйн нэгжүүд, төрийн бус байгууллагууд, нийгэмлэг холбоо, хөршийн холбоо зэрэг нь ажилчид болон харьяалагдах иргэдийг цусаа хандивлахад идэвхтэй оролцохыг уриалж, зохион байгуулах үүрэгтэйгээр хуульчлагджээ. Төрийн албан хаагчид, цэргийн алба хаагчид болон дээд боловсролын сургуулийн оюутнуудыг цусаа хандивлах үйлсэд манлайлан оролцохыг төрөөс дэмжиж, нийгмийн шинэ хандлагад үлгэр дуурайлал үзүүлэх болно гэж үздэг байна.

Улсын зөвлөлийн дэргэдэх Нийгмийн эрүүл мэндийн хэлтсээс авлагагүй цус хандивласан тухай гэрчилгээг цусны доноруудад олгож, холбогдох нэгжүүд зохих тэтгэмжийг олгох замаар нийгмийн халамжийг хэрэгжүүлдэг байна..

Цусны төвүүд нь эмнэлзүйн хэрэгцээнд зориулан цус цуглуулж, хангадаг байгууллага бөгөөд ашиг олох зорилгогүй ашгийн бус байгууллага бөгөөд иргэдээс цус авах цусны төв байгуулахдаа Төрийн Зөвлөлийн дэргэдэх Нийгмийн эрүүл мэндийн газар, аймаг, муж , хотын ардын засгийн газрын дэргэдэх Нийгмийн эрүүл мэндийн хэлтсээс зөвшөөрөл авсны үндсэн дээр байгуулснаар засгийн газрын шууд харьяа байгууллага болдог байна.

Цусны төв нь цусны доноруудад аюулгүй, эрүүл ахуй, тав тухтай нөхцлийг бүрдүүлэх ёстой. Цусны төвд тавигдах шаардлага, удирдлагын арга хэмжээг Төрийн зөвлөлийн дэргэдэх Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс боловсруулж, цусны төвд цусны донорын шаардлагатай эрүүл мэндийн үзлэгийг үнэ төлбөргүй хийх ёстой бөгөөлц цусны донорын эрүүл мэндийн байдал нь цусны донорын шаардлагад нийцэхгүй байгаа иргэдэд нөхцөл байдлыг тайлбарлаж, цусаа авахгүй байх үүрэгтэй. Цусны донорын биеийн эрүүл мэндийн байдлыг Төрийн зөвлөлийн дэргэдэх Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс тогтоодог байна.

Цусны төвд цусны донороос нэг удаад авах цусны хэмжээ ерөнхийдөө 200 мл, дээд тал нь 400 мл-ээс хэтрэхгүй байх ёстой бөгөөд хоёр цус цуглуулах хоорондох хугацаа зургаан сараас багагүй байна.

Иргэн зөвхөн эмнэлзүйн хэрэглээнд байгаа цусыг цуглуулах, хадгалах, ялгах, шалгахад гарсан зардлыг төлдөг бөгөөд энэ хэмжээг Төрийн зөвлөлийн дэргэдэх Нийгмийн эрүүл мэндийн газар, Төрийн зөвлөлийн дэргэдэх үнийн хэлтэстэй хамтран тогтоодог ажээ.

Цусны донор нөхөн төлбөргүйгээр цус хэрэглэх эмнэлзүйн зайлшгүй шаардлагатай тохиолдолд өмнөх хэсэгт заасан зардлаас чөлөөлөгдөнө. Цусны донорын эхнэр, нөхөр, ураг төрлийн хамаатан садан нь нөхөн төлбөргүйгээр цус авах шаардлагатай бол өмнөх хэсэгт заасан зардлаас чөлөөлөх, бууруулах шийдвэрийг аймаг, муж, хотын ардын Засгийн газрын тогтоолын дагуу болон Төв Засгийн газар шийдвэрлэдэг байна.

# ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

## 7.1. Дүгнэлт

Цусны донорын тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны ажлыг бүхэлд нь нэгтгэн дүгнэвэл дараах хэд хэдэн үндсэн харилцааг тусгайлсан хууль тогтоомж батлан тухайн хуулиар зохицуулах шаардлагатай байна. Үүнд:

1. Цусны донорын үйл ажиллагаан дахь төрийн зохицуулалт, хяналттай холбоотой харилцаа;

2. Цусны донорын харилцаанд оролцогч байгууллагууд, үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо, харилцаанд оролцогч талууд, түүний дотор цусны донорын үйл ажиллагаа хариуцсан байгууллага, цусны салбар төв, нутгийн өөрөө удирдах байгууллага, засаг дарга, бусад байгууллагын эрх, үүрэгтэй холбоотой харилцаа;

4. Цусны донорын үйл ажиллагааны санхүүжилттэй холбоотой харилцаа;

5. Цусны донор, сэлбүүлэгч, цус сэлбэлт судлалын салбарын эмнэлгийн мэргэжилтэнд тавигдах шаардлага, тэдгээрийн эрх, үүрэгтэй холбоотой харилцаа;

6. Донороос цус, түүний бүрэлдэхүүн хэсэг авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, сэлбэх, устах үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэх эрүүл мэндийн байгууллагуудтай холбоотой харилцаа;

7. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед цусны донорын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцаа;

8. Цусны донорын мэдээллийн сантай холбоотой харилцаа;

9. Цусны донорын алдаршуулалт, урамшуулалт, тэдгээрт үзүүлэх дэмжлэгтэй холбоотой харилцаа.

Дээрх дүгнэлтэд үндэслэн судалгааны багийн зүгээс Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны... үндсэн дээр үзэл баримтлалын төсөл боловсруулна.", мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д "Хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулна." хэмээн тус тус заасны дагуу Цусны донорын **тухай** хуулийг төслийн үзэл баримтлалыг боловсруулах, түүн дээр үндэслэн хуулийн төслийг тус тус боловсруулах зайлшгүй шаардлагатай гэж дүгнэлээ.

## 7.2. Зөвлөмж

Судалгааны ажлын 7.1 дэх хэсэгт заасан дүгнэлтэд үндэслэн Цусны донорын тухай хуулийн төсөл боловсруулахад зайлшгүй анхаарвал зохих дараах хэд хэдэн зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэгт заасны дагуу Цусны донорын тухай хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан энэхүү үйл ажиллагааг зохицуулсан бусад хууль тогтоомжийг зайлшгүй анхаарч, хууль тогтоомжийн давхардал эсхүл хийдэл үүсэхэд анхаарч ажиллах;

2. Цусны донорын үйл ажиллагаан дахь төрийн зохицуулалт, хяналтыг тусгах;

3. Цусны донорын харилцаанд оролцогч байгууллагуудыг тодорхойлж, үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо, харилцаанд оролцогч талууд, түүний дотор цусны донорын үйл ажиллагаа хариуцсан байгууллага, цусны салбар төв, нутгийн өөрөө удирдах байгууллага, засаг дарга, бусад байгууллагын эрх, үүргийг тусгах;

4. Цусны донорын үйл ажиллагааны санхүүжилтийг улсын төсөв, үндсэн үйл ажиллагааны орлого, гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хандиваар бүрдүүлж, эргэлтийн сан бий болгох, цусны донорын үйл ажиллагаанд аж ахуйн нэгж байгууллагын зарцуулсан зардлыг орлогын албан татвараас чөлөөлөх зохицуулалтыг тусгах;

5. Цусны донор, сэлбүүлэгч, цус сэлбэлт судлалын салбарын эмнэлгийн мэргэжилтэнд тавигдах шаардлага, тэдгээрийн эрх, үүргийг тусгах;

6. Донороос цус, түүний бүрэлдэхүүн хэсэг авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, сэлбэх, устах үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэх эрүүл мэндийн байгууллагуудтай холбоотой харилцааг тусгах;

7. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед цусны донорын үйл ажиллагааг хэрэгжүүлэх онцлог, энэ үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүргийг тусгах;

8. Цусны донорын мэдээллийн сан бий болгох ажиллуулах байгууллага, түүний аюулгүй байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагааг тусгах;

9. Цусны донорын алдаршуулалт, урамшуулалт, тэдгээрт үзүүлэх дэмжлэгтэй холбоотой үйл ажиллагаа, түүний дотор Хүндэт донор тэмдэгийг Засгийн газрын шагнал болгох, Хүндэт донорыг төрийн шагналд нэр дэвшүүлэх үйл ажиллагааг тусгах.

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ


1. ЭМХТ, ДЭМБ-аас эрхлэн гаргасан Эрүүл мэндийн үзүүлэлт тайлан 2020 он
2. ЭМХТ, ДЭМБ-аас эрхлэн гаргасан Эрүүл мэндийн үзүүлэлт тайлан 2021 он
3. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1962 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн ""Хүндэт донор" гэдэг энгэрийн тэмдэг бий болгох тухай" 19 дүгээр тогтоол
4. Гүрж улсын Цусны донорын тухай хууль
5. ОХУ-ын Цусны донорын тухай хууль
6. БНХАУ-ын Цусны донорын тухай хууль
7. Монгол Улсын төрөөс донорын цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан 2016 он
8. https://www.populationpyramid.net/mongolia/2020/
9. ЦССҮТ-ийн статистик мэдээ
10. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай комисст хүргүүлсэн 2020 оны 02 сарын 05-ны өдрийн 59 тоот албан бичиг
11. ЦССҮТ-ийн хүний нөөцийн судалгаа 2014-2021 он
12. ЦССҮТ-ийн статистик өгөгдөлд тулгуурлан регресс үнэлгээ хийсэн загварчлал
13. Эрүүл мэндийн салбар Судалгааны материал, ном, цахим эх сурвалж /БИЧИХ/
14. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах жилийн хүрээнд зохион байгуулсан "Цусны аюулгүй байдлыг хангах нь" сэдэвт Цусны салбар төвийн эрхлэгч, эмч, тусгай мэргэжилтнүүдийн семинар /цахим, танхим хослуулсан/ -ын үед хийсэн ярилцалага, санал асуулга
15. Цусны донорууд, асуумжийн дүн
16. Цус сэлбэлт судлалын салбарын эрүүл мэндийн ажилтнуудаас авсан асуумжийн дүн
17. Монголын донорын холбоотой хамтран зохион байгуулсан хэлэлцүүлгээс гарсан санал

**Хавсралт -1: Хувилбарын хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг үнэлсэн байдал**

**ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ**

| **Үзүүлэх үр нөлөө** | **Холбогдох асуулт** | **Хариулт** | | **Тайлбар** |
|---|---|---|---|---|
| 1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх | 1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх | | | |
| | 1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх | **Тийм** | Үгүй | |
| | 1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх | Тийм | **Үгүй** | |
| | 1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх | **Тийм** | Үгүй | |
| | 1.2.Оролцоог хангах | | | |
| | 1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх | Тийм | **Үгүй** | |
| | 1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх | **Тийм** | Үгүй | |
| | 1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага | | | |
| | 1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх | **Тийм** | Үгүй | |
| | 1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх | **Тийм** | Үгүй | |
| | 1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх | **Тийм** | Үгүй | |
| 2.Хүний эрхийг | 2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх | **Тийм** | Үгүй | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх | 2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх | **Тийм** | Үгүй | |
